



Монголын Усан Спорт Сонирхогчдын Холбоо

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

2023 ОНЫ 08 САРЫН 16-НЫ
ӨДРӨӨС ХҮЧИН ТӨГӨЛДӨР
ҮЙЛЧИЛНЭ



АГУУЛГА

НЭГ ДҮГЭЭР БҮЛЭГ – НИЙТЛЭГ ТОДОРХОЙЛОЛТ	3
1. ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ	7
2. ТАЙЛБАР	7
3. МУССХ-НЫ ГИШҮҮН БАЙГУУЛЛАГУУД	8
4. ЁС ЗҮЙН ДҮРМИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ХУВЬ ХҮН, АЛБАН ТУШААЛТАН	8
ХОЁР ДУГААР БҮЛЭГ – ЕРӨНХИЙ ҮҮРГҮҮД	9
5. ЁС ЗҮЙН ДҮРМЭЭР ХҮЛЭЭХ ҮҮРЭГ	9
6. МЭДЭЭЛЭХ, ХАМТРАН АЖИЛЛАХ ҮҮРЭГ	10
7. НУУЦЫГ ХАДГАЛАХ ҮҮРЭГ	10
8. ТӨВИЙГ САХИХ ҮҮРЭГ	11
9. АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС АНГИД БАЙХ ҮҮРЭГ	11
10. ХӨРӨНГӨ МӨНГИЙГ ХУВЬДАА АШИГЛАХ, ХУУРАН МЭХЛЭХ	12
11. БЭЛЭГ ӨГӨХ, БЭЛЭГ АВАХ	13
12. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ, ТЕНДЕР	13
13. СОНГУУЛЬ	14
14. ЁС ЗҮЙН ДҮРМИЙН СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА	15
ГУРАВ ДУГААР БҮЛЭГ – ХУУРАН МЭХЛЭЛТ, ТҮҮНЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ	16
15. АВЛИГЫН ЭСРЭГ ДҮРЭМ	16
16. БООЦООНЫ БАЙГУУЛЛАГАТАЙ ХОЛБООТОЙ ХАРИЛЦАА	17
ДӨРӨВ ДҮГЭЭР БҮЛЭГ – ЁС ЗҮЙН ДҮРМИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ	18
17. МУССХ-НЫ ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛ	18
18. ХЯНАЛТ	18
19. МЭДЭЭЛЭХ	19
20. ЗӨРЧЛИЙГ ШИЙДВЭРЛЭХ	19
21. ТҮР ТҮТГЭЛЗҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ	20
22. ЁС ЗҮЙН ДҮРМИЙН БОЛЗОШГҮЙ ЗӨРЧЛИЙГ ШАЛГАХ	21
23. МЭДЭГДЭЛ	21
24. БОЛЗОШГҮЙ ЁС ЗҮЙН ЗӨРЧЛИЙН НОТЛОХ БАРИМТЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ	23
25. ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ БҮРЭЛДЭХҮҮНИЙГ ТОМИЛОХ	23
26. ЭСЭРГҮҮЦЭЛ	24
27. ХАРИУЦАГЧИЙН ХАРИУ ТАЙЛБАР	24
28. НЭМЭЛТ МЭДҮҮЛЭГ БОЛОН НЭМЭЛТ НОТЛОХ БАРИМТУУД	25
29. СОНСГОЛ	25
30. ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	25
31. БАРИМТ НОТОЛГООГ ШИНЖЛЭН СУДЛАХ	26
32. ШИЙДВЭР ГАРГАХ ҮЙЛ ЯВЦ	26
33. ШИЙТГЭЛ	27
34. ЗАРДАЛ	29
35. УДИРДАХ ЗӨВЛӨЛД ДАВЖ ЗААЛДАХ	30
36. ШИЙДВЭРИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ	30
37. ДҮГНЭЛТ ГАРГАХ	31



НЭГ ДҮГЭЭР БҮЛЭГ – НИЙТЛЭГ ТОДОРХОЙЛОЛТ

ТОДОРХОЙЛОЛТ

Ёс зүйн зөвлөл: МУССХ-ны дүрмийн 13.4 зүйлд заасны дагуу бий болсон бүтэц

Усан спорт: МУССХ-ны үйл ажиллагаанд харьяалагдан зохицуулагддаг усанд сэлэлт, задгай усанд сэлэлт, усанд үсрэлтийн төрлүүд, усан поло, уран сайхны сэлэлт, усанд сэлэлтийн мастерсийн төрлүүд

Ёс зүйн зөвлөлийн гишүүд: Ёс зүйн зөвлөлд сонгогдсон гишүүд

Ёс зүйн зөвлөлийн дарга: Ёс зүйн зөвлөлийн гишүүдээс олонхийн санал авч сонгогдсон хүн

Тамирчин: Дэлхийн усан спортын холбоо болох World Aquatics болон МУССХ-ны дүрэм, журмын хүрээнд зохион байгуулагдаж байгаа олон улс, улсын чанартай усан спортын тэмцээн, уралдаанд оролцож буй хүн

Тамирчныг туслан дэмжигч: Тамирчныг усан спортын тэмцээн уралдаанд бэлтгэн оролцуулж буй дасгалжуулагч, менежер, агент, багийн гишүүд, албаны хүмүүс, багийн эмч

Ашиг хонжоо: Шууд болон шууд бусаар мөнгө буюу түүнтэй адилтгах үнэт зүйлсийг өөртөө болон хамаарал бүхий (гэр бүлийн гишүүд, хамтрагч, эцэг эх, үр хүүхэд, найз нөхөд) этгээдээр дамжуулан хүлээн авах, өгөх. Үүнд: хээл хахууль, бэлэг, бооцооны хожил гэх мэт. Харин албан ёсны шагналын мөнгө, оролцооны татвар, ивээн тэтгэлэг болон гэрээний үндсэн дээр олгогдсон төлбөр хамаарахгүй.

Бооцоо тавих: Усан спортын тэмцээн болон усан спорт хөтөлбөрт нь орсон ямар нэг арга хэмжээний үеэр мөнгөн үнэ цэнэ бүхий ашиг олох зорилгоор үр дүн нь тодорхой бус зүйлд бооцоо, мөрий байршуулах, тавих

Бооцооны байгууллага: Бүх төрөл хэлбэрийн бооцооны үйл ажиллагааг зохион байгуулдаг байгууллага, хувь хүн

CAS: Швейцарийн Лозанн дахь Спортын арбитрын шүүх.

Хууль тогтоомж: Монгол улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хуулиуд

Дүрэм: МУССХ-ны дүрэм

Үйлчлэлд хамаарах этгээд: Үйлчлэлд хамаарах этгээд гэж

- а) МУССХ-ны албан тушаалд томилогдсон, сонгогдсон албан тушаалтан болон томилогдож сонгогдохоор нэр дэвшиж байгаа хүмүүс
- б) Бүх тамирчид
- в) Тамирчныг туслан дэмжигч



- г) Холбооны арга хэмжээнд оролцож буй баг эсвэл байгууллага
- д) МУССХ-ны гишүүд, гишүүн байгууллага, клубууд
- е) МУССХ-ны гишүүн байгуулагуудын гишүүд, клубууд

Хянан шийдвэрлэх бүрэлдэхүүн: Болзошгүй ёс зүйн зөрчлийн хэргийг шийдвэрлэхээр Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнээс гурван (3) гишүүнийг томилох

Хянан шийдвэрлэх бүрэлдэхүүний дарга: Ёс зүйн зөвлөлийн дарга өөрийн бүрэлдэхүүнээс Хянан шийдвэрлэх бүрэлдэхүүний даргад томилсон хүн

Шийдвэр: Хянан шийдвэрлэх бүрэлдэхүүний шийдвэр

Шаардлага: Үйлчлэлд хамаарах этгээдээс Ёс зүйн зөрчлийн асуудлаар нотлох баримтыг олох, үндэслэл бүхий нэмэлт мэдээлэл авах зорилгоор Ёс зүйн зөвлөлийн дарга, гишүүдээс бичгээр гаргасан хүсэлт

Арга хэмжээ: МУССХ-ны дүрмийн дагуу зохион байгуулагдсан аливаа тэмцээн, хурал зөвөлгөөн, сургалт, бусад арга хэмжээнүүд

Бэлэг: Өөрт нь болон гэр бүлийнхэн, хамаарал бүхий этгээдэд нь ашиглах зорилго бүхий бусдаас үнэ төлбөргүй өгсөн бүх төрлийн эд зүйлс

Зочломтгой байдал: Гэрээний дагуу зохицуулагдаж олгогдсноос бусад тохиолдолд үйлчлэлд хамаарах этгээдийг болон түүний гэр бүл, хамаарал бүхий этгээдийг үнэ төлбөргүй орон байр, хоол хүнс, унаа тэргээр үйлчлэх, шоу цэнгээн, тоглолт бусад бүх төрлийн арга хэмжээнд урих

Дотоод мэдээлэл: Үйлчлэлд хамаарах этгээдийн МУССХ-нд хашиж буй албан тушаал, холбоо харилцааныхаа шугмаар олж авсан, хэвлэл мэдээлэл болон бүх гишүүдэд зориулснаас бусад бүх төрлийн мэдээлэл

Ёс зүйн дүрмийн зөрчил: Үйлчлэлд хамаарах этгээд нь:

- Энэхүү Ёс зүйн дүрэмд заасан шаардлагуудын аль нэгийг зөрчсөн, эсвэл;
- Ёс зүйн зөрчил үүсгэж болзошгүй ямар нэг гэрээ тохиролцоог бусад этгээдтэй хийсэн, хийхийг завдсан
- Хэн нэгнийг ёс зүйн зөрчилд оруулж болзошгүй харилцаанд орохыг уриалах, турхирах, зааварлах, ятгах эсвэл
- Ёс зүйн зөрчлийн аливаа үйлдлийг хүлээн зөвшөөрсөн, мэдсээр байж туслаж дэмжсэн, нуун дарагдуулж хамгаалсан аливаа үйлдэл, эс үйлдлийг ёс зүйн дүрмийн зөрчил гэж үзнэ



Тайлбар: Дүрмийн 11 дүгээр зүйлд заасан зөрчлийн үед, МУССХ-ны Ерөнхийлөгч, Ерөнхий нарийн бичгийн дарга (эсвэл түүнтэй адилтгах түвшний хүмүүс) өөрийн удирдлага доор ажиллаж байгаа ажилтан, зөвлөх, төлөөлөгчдийн гаргасан зөрчлийн үйлдэлд холбоогүй гэдгээ нотлон тайлбарлах үүрэгтэй. Тайлбар гаргагч албан тушаалтан нь өөрийнх нь зөрчилд хамтран оролцсон байж болох бүх сэжиг таамгийг ёс зүйн зөвлөлд үгүйсгэн нотлож тайлбарлах үүрэгтэй.

Үр дүнд нөлөөлөх, хуурамчаар өөрчлөх: Холбооны бүх төрлийн арга хэмжээний үйл явц, үр дүнд өөртөө болон бусдад давуу байдал бий болгох зорилгоор нөлөөлөх, эсвэл санаатайгаар өөрчлөх

Албан тушаалтнууд: Холбооны Удирдах зөвлөлийн гишүүд, Зөвлөлийн гишүүд, ажилтнууд болон холбоог төлөөлөн арга хэмжээнд оролцож байгаа төлөөлөгчид

- МУССХ-ны төлөө эсвэл түүний нэрийн өмнөөс ажилладаг ажилтан, төлөөлөгч, зөвлөх гэх мэт бүх хүмүүс
- Усан спортын бүх төрлийн үйл ажиллагаанд ажиллахаар эсвэл сайн дурын ажил хийхээр томилогдсон/сонгогдсон техникийн ажилтнууд, төрөлжсөн зөвлөлүүдийн төлөөлөл болон МУССХ-г төлөөлөхөөр итгэмжлэгдсэн хүмүүс
- Усан спортын арга хэмжээ, сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулж байгаа болон зохион байгуулахаар сонгон шалгаруулалтад орж байгаа байгууллагын албан хаагчид, сайн дурынхан, тэднийг төлөөлөн арга хэмжээнд оролцож байгаа хүмүүс
- Энэхүү ёс зүйн дүрмийг дагаж биелүүлэхээ бичгээр зөвшөөрсөн бүх хүмүүс

Ашиг сонирхлын зөрчлийн тэмдэглэл: Албан тушаалтнууд өөрсдөө болон тэдний талаар бусад этгээдийн мэдээлсэн ашиг сонирхлын зөрчлийн талаархи мэдээлэл. Тус тэмдэглэлийг Ёс зүйн зөвлөл хариуцан хөтлөнө.

Нотлох баримт: Ёс зүйн болзошгүй зөрчлийн талаархи мэдээлэгч болон хариуцагчийн мэдүүлэг, тайлбар, бусад бүх баримтууд, гэрчийн мэдүүлэг, эд мөрийн баримт, шинжээчийн дүгнэлт

Талууд: Нэг талд МУССХ болон түүний Ёс зүйн зөвлөл, нөгөө талд Үйлчлэлд хамаарах этгээд

Хариуцагч: Болзошгүй ёс зүйн зөрчлийн хэрэгт сэжиглэгдэж буй этгээд

Журам: МУССХ-ны дүрмийн хүрээнд гаргасан бүх төрлийн журам түүний нэмэлт өөрчлөлтүүд

Гомдол, мэдээлэл: Ёс зүйн дүрмийн болзошгүй зөрчлийн талаар болон зөрчилд хамтран оролцуулахаар хандсан, хүссэн талаархи бүх мэдээллүүд

Мэдээлэгч: Ёс зүйн дүрмийн болзошгүй зөрчил болон зөрчилд хамтран оролцуулахаар хандсан, хүссэн талаархи мэдээллийг Ёс зүйн зөвлөлд анх мэдүүлсэн этгээд

Сонсгол: Хянан шийдвэрлэх бүрэлдэхүүн оролцогч талуудыг гэрчээр дуудан мэдүүлэг авах, шийдвэр гаргах үйл явц



Ажилтан: МУССХ-ны бүтэн болон хагас цагийн ажилчид, гэрээт ажилчид эсвэл төлөөлөгч болон зөвлөхийн журмаар хамтран ажиллаж байгаа хүмүүс

Хамтран ажиллах: гэдэгт

- Үйлчлэлд хамаарах этгээд нь Ёс зүйн дүрэм болон бусад дүрэм журмын болзошгүй зөрчлийн талаархи тодорхой, бүрэн гүйцэд, ач холбогдол бүхий мэдээлэл өгөх
- Ёс зүйн дүрмийн болон бусад хууль тогтоомжийн зөрчилтэй холбоотой мөрдөн шалгах ажилд Ёс зүйн зөвлөл болон Хууль хяналтын байгууллагуудтай хамтран ажиллах, шаардлагатай тохиолдолд мэдүүлэг өгч гэрчээр оролцох

World Aquatics: Дэлхийн усан спортын цорын ганц удирдах байгууллага. Хуучин нэршлээр FINA.

World Aquatics-ын гишүүн: Дэлхийн усан спортын байгууллагын (World Aquatics) хүлээн зөвшөөрсөн үндэсний усны спортын байгууллага



НЭГ. ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ

- 1.1 Энэхүү ёс зүйн дүрмийг тамирчдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, спортын эв нэгдлийг хангаж олон нийтийн дунд нэр хүнд нь унахаас сэргийлэх, шийдвэр гаргалтын шударга байдлыг хангаж, дүрмийг зөрчсөн этгээдүүдэд хариуцлага тооцох зорилгоор МУССХ-ны бүх төрлийн үйл ажиллагаа болон арга хэмжээнд оролцож байгаа хүмүүст мөрдүүлэхээр батлав.
- 1.2 МУУСХ нь усан спортын үндэсний холбооны хувьд өөрийн удирдлага, засаглалын бүх түвшинд энэхүү ёс зүйн дүрмийг чанд мөрдөн ажиллана.
- 1.3 МУССХ нь тэмцээний үеийн баг/тамирчдын шударга бус өрсөлдөөн, тэдний ур чадвар, амжилтын эсрэг шударга бус шүүлт, хууран мэхлэлтийн эсрэг ёс зүйн дүрмийг мөн ашиглана.
- 1.4 Ёс зүйн дүрмээр хориглосон зарим үйлдэл нь эрүүгийн болон захиргааны хууль тогтоомжийн эсрэг гэмт хэрэгт тооцогдож болох бөгөөд энэхүү дүрэм нь тухайн хууль тогтоомжийг орлох үүрэг зорилгогүй болно.
- 1.5 Энэхүү ёс зүйн дүрэм нь МУССХ-ны бусад дүрэм журмаар хориглосон заалтуудтай давхцаж болно.
- 1.6 МУССХ-ны Хүчирхийллийн эсрэг дүрэм болон Сэргээшийн хяналтын дүрэм нь энэхүү Ёс зүйн дүрмийн нэг хэсэг биш юм.
- 1.7 Энэхүү ёс зүйн дүрэм нь 2023 оны 08 сарын 16 -ны өдрөөс эхлэн хэрэгжих эхлэх бөгөөд хэрэгжиж эхлэхээс өмнөх аливаа ёс зүйн зөрчлийг энэхүү дүрмээр зохицуулахыг хориглоно.

ХОЁР. ТАЙЛБАР

- 2.1 Энэхүү ёс зүйн дүрмийн Нэг дүгээр бүлэгт онцгойлон тайлбарласнаас бусад үг хэллэгийг утгын дагуу ашиглана.
- 2.2 Тайлбар хэсэг нь Ёс зүйн дүрмийн тухайн зүйл, заалтыг хэрхэн хэрэглэх, утга санааг нь яаж ойлгохыг заана.
- 2.3 Ёс зүйн дүрмийн тухайн зүйл заалтад онцгойлон заагаагүй л бол энэхүү дүрмэнд ашигласан ганц тооны утганд олон тоог мөн хамааруулан ойлгоно.
- 2.4 Хэдийгээр Ёс зүйн дүрмийн заалтыг гажуудуулсан, талуудад ижил тэгш бус байдлаар хандсан, техникийн болон үйл ажиллагааны алдаатай шийдвэр гарсан гэж маргаж байгаа боловч түүнийг нь Хянан шийдвэрлэх бүрэлдэхүүн хэлэлцэж, шийдвэр гаргах хүртэл өмнөх шийдвэр хүчин төгөлдөр байна.



2.5 Энэхүү Ёс зүйн дүрмийн аль нэг хэсгийг дүрмийн бус, хэрэгжүүлэх боломжгүй гэж Удирдах зөвлөл үзвэл зөвхөн тухайн хэсгийг хүчингүй болсонд тооцож Ёс зүйн дүрмийн хэрэгжилт хэвээр үргэлжилнэ.

2.6 Ёс зүйн дүрэмтэй холбоотой аливаа дутагдал, урьдчилан таамаглах боломжгүй нөхцлүүдийг засаж сайжруулах зорилгоор Ёс зүйн дүрэм болон дүрмийн тухайн зүйл заалтын зорилго, утгыг алдагдуулахгүйгээр нэмэлт өөрчлөлт, найруулгыг хийж болно.

2.7 Энэхүү Ёс зүйн дүрэм нь зөвхөн Спортын арга хэмжээтэй холбоотой харилцаанд зориулагдсан бөгөөд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа болон ажил эрхлэлттэй холбоотой асуудлыг зохицуулахад ашиглагдахгүй. Ёс зүйн дүрэм болон эрх зүйн харилцааны зааг ялгааг зөв ойлгож хэрэглэх нь Ёс зүйн дүрмийн нэр хүндийг хадгалахад чухал ач холбогдолтой.

2.8 МУССХ (албан хаагчид, гишүүд, ажилтнууд, сайн дурынхан, Ёс зүйн зөвлөлийн гишүүд) нь Ёс зүйн зөрчлийг шалгах, хянан шийдвэрлэх явц болон тухайн явцад албан тушаалтны санаатай болон санамсаргүйгээр гаргасан аливаа үйлдэл, эс үйлдлийн төлөө хэний ч өмнө хариуцлага хүлээхгүй.

ГУРАВ. МУССХ-НЫ ГИШҮҮН БАЙГУУЛЛАГУУД

3.1 МУССХ-ны гишүүн байгууллага, клуб бүр энэхүү Ёс зүйн дүрмийг хүлээн зөвшөөрч өөрийн үйл ажиллагаанд оролцож буй бүх хүмүүст дагаж мөрдүүлэх үүрэгтэй. Мөн холбооны гишүүн байгууллага, клубууд энэхүү дүрмийн хүрээнд өөрсдийн үйл ажиллагаанд мөрдөх ёс зүйн дүрмийг боловсруулан гаргаж болно.

3.2 Нээлттэй, ил тод байдлыг хангах зорилгоор МУССХ-ны гишүүн байгууллага, клубууд өөрсдийн Ёс зүйн дүрмийг боловсруулан гаргахдаа, мөн тухайн дүрмийнхээ хүрээнд ямар нэгэн үйл ажиллагаа, шийдвэр гаргахдаа МУССХ-нд урьдчилан мэдэгдэх бөгөөд арга зүйн туслалцаа авч болно.

ДӨРӨВ. ЁС ЗҮЙН ДҮРМИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ХУВЬ ХҮН, АЛБАН ТУШААЛТАН

4.1 Энэхүү ёс зүйн дүрмийг доорхи хүмүүс дагаж мөрдөнө

- а) МУССХ-ны сонгогдсон болон томилогдсон бүх албан тушаалтнууд
- б) Бүх тамирчид
- в) Тамирчныг туслан дэмжигчид
- г) Холбооны бүх төрлийн арга хэмжээнд оролцож байгаа баг, хамт олон
- д) МУССХ-ны гишүүд, гишүүн байгууллага, клуб
- е) МУССХ-ны гишүүн байгууллага, клубын гишүүд
- ж) МУССХ-ны арга хэмжээг зохион байгуулж байгаа болон зохион байгуулахаар төлөвлөж байгаа эсвэл нэр дэвшиж байгаа хувь хүн албан байгууллагууд



4.2 Ёс зүйн дүрмийн үйлчлэлд хамаарч байсан этгээд тухайн ажил, үүргээ эрхлэхээ больсон эсвэл чөлөөлөгдсөн өдрөөс эхлэн энэхүү Ёс зүйн дүрмийн үйлчлэлийг зогсооно.

4.3 Ёс зүйн дүрэмд хамаарах зөрчил гаргасан этгээд тухайн ажил, үүргээ эрхлэхээ больсон эсвэл чөлөөлөгдсөн бол Ёс зүйн дүрмийн үйлчлэл зогсохгүй бөгөөд хяналт шалгалтыг энэхүү дүрмийн дагуу явуулна.

4.4 Ёс зүйн зөрчилд холбогдон шалгагдаж байгаа этгээд тэтгэвэрт гарсан эсвэл буруугаа хүлээж чөлөөлөгдөх хүсэлтээ өгснөөс бусад тохиолдолд шалгалтыг үргэлжлүүлнэ.

4.5 Хэрэв ёс зүйн дүрмийн заалт тодорхой нэгэн албан тушаалтан болон этгээдэд хамаарахаар заасан бол бусад этгээдэд хамааруулан хэрэглэхийг хориглоно.

4.6 Ёс зүйн дүрмийн үйлчлэлд хамаарах этгээд Ёс зүйн дүрмийн зорилго, агуулгатай танилцсан байх үүрэгтэй

ХОЁР ДУГААР БҮЛЭГ – ЕРӨНХИЙ ҮҮРГҮҮД

ТАВ. ЁС ЗҮЙН ДҮРМЭЭР ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

5.1 Үйлчлэлд хамаарах этгээд нь Ёс зүйн дүрмийн хүрээнд үнэнч шударгаар, ёс суртахууны өндөр түвшинд үйл ажиллагаагаа явуулна.

5.2 Үйлчлэлд хамаарах этгээд нь Ёс зүйн дүрмийг ямар нэгэн байдлаар зөрчих үйлдэл, эс үйлдэл хийхээс зайлсхийнэ.

5.3 Үйлчлэлд хамаарах этгээд нь усан спортыг гутаан доромжлох, усан спорт болон МУССХ-ны нэр хүндийг унагаах үйлдэл, эс үйлдэл хийхээс зайлсхийнэ.

5.4 Үйлчлэлд хамаарах этгээд нь Ёс зүйн дүрэмд заасан зарчимд нийцэхгүй үйл ажиллагаа явуулдаг байгууллага, хувь хүмүүстэй холбоо тогтоох, явуулж буй үйл ажиллагаанд нь хамрагдахгүй.

5.5 Үйлчлэлд хамаарах этгээд нь албаны хүмүүс, сэргээшийн хяналтын албаныхан, бусад тамирчид, хэвлэл мэдээлэл болон үзэгчдийн эсрэг заналхийлсэн, хүчирхийлсэн, үл хүндэтгэсэн зан авир гаргахыг хориглоно.

5.6 Үйлчлэлд хамаарах этгээд нь хэнийг ч үндэс угсаа, арьсны өнгө, нас хүйс, шашин шүтлэг, бэлгийн чиг хандлага, хэл соёл, улс төрийн болон бусад үзэл бодол, өмч хөрөнгө, хөгжлийн бэрхшээл болон бусад бүх үндэслэлээр ялгаварлан гадуурхахаас зайлсхийнэ.

5.7 Үйлчлэлд хамаарах этгээд нь спортын арга хэмжээний үйл ажиллагаа, зохион байгуулалтад саад учруулах, хөндлөнгөөс оролцох, тогтоосон дэгийг зөрчихөөс зайлсхийнэ. Энэ заалт нь усан сангийн бүх хэсэг болон тухайн арга хэмжээний гадна талбайд болсон зөрчилд ч хамаарна.



5.8 Үйлчлэлд хамаарах этгээд нь тэмцээний бүхий л үйл ажиллагаа буюу нээлт, хаалт, шагнал гардуулах ёслол болон шаардлагатай тохиолдолд танилцуулга, хэвлэлийн хуралд идэвхтэй оролцох үүрэгтэй. Энэ үеэр улс төрийн болон шашны аливаа мэдэгдэл, зан үйл хийхийг хатуу хориглоно.

5.9 Тамирчид, тамирчны туслан дэмжигчид нь сэргээшийн эсрэг хөтөлбөрийг дэмжиж, дэлхийн сэргээшийн эсрэг дүрмээр хориглосон ямар нэг бэлдмэл, зан үйлийг ашиглахгүй.

ЗУРГАА. МЭДЭЭЛЭХ, ХАМТРАН АЖИЛЛАХ ҮҮРЭГ

Үйлчлэлд хамаарах этгээд нь доорхи үүргийг хүлээнэ.

6.1 Ёс зүйн дүрмийн зөрчилд хамаарах ямар нэгэн үйлдэл хийхийг шаардсан, хамтран ажиллахыг санал болгосон талаархи мэдээллийг цаг алдалгүй Ёс зүйн зөвлөлд мэдээлэх.

6.2 Бусдын Ёс зүйн дүрмийг зөрчсөн үйлдэл болон баримтыг, мөн зөрчилтэй холбоотой аливаа сэжигтэй үйлдлийн баримтыг цаг алдалгүй Ёс зүйн зөвлөлд мэдээлэх.

Тайлбар: Өмнө нь мэдээлсэн зөрчилтэй холбоотой аливаа шинэ үйлдэл, баримтыг үргэлжлүүлэн цаг алдалгүй Ёс зүйн зөвлөлд мэдээлнэ.

6.3 Ёс зүйн дүрмийн болзошгүй зөрчлийн мөрдөн шалгалтын ажлыг туслан дэмжиж, Ёс зүйн зөвлөлийн хүссэн мэдээлэл, баримтуудыг бэлтгэж өгөх

Тайлбар: Зөрчлийн мөрдөн шалгалтын явцад шаардлагатай баримт мэдээллийг нуун дарагдуулах, устгах болон устгахыг оролдох зэргээр саад учруулах нь Ёс зүйн дүрмийн зөрчилд хамаарна.

ДОЛОО. НУУЦЫГ ХАДГАЛАХ ҮҮРЭГ

7.1 Үйлчлэлд хамаарах этгээд нь хувийн ашиг сонирхол болон өөртөө давуу байдал олж авах зорилгоор МУССХ-ны хийж байгаа гэрээ хэлэлцээр, үйл ажиллагааны талаархи мэдээллийн нууцыг тухайн асуудлаар ашиг сонирхлын зөрчилтэй гуравдагч этгээдэд задруулахыг хориглоно. Монгол улсын хуулийн хүрээнд, эсвэл МУССХ-ноос бичгээр гаргасан зөвшөөрлийн дагуу задарсан мэдээллүүд болон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэгэнт олонд ил болсон зүйлийг энэхүү зөрчилд хамааруулахгүй. Тухайн этгээд Ёс зүйн дүрмийн үйлчлэлд хамаарахаа больсон ч Ёс зүйн дүрмээр хүлээсэн нууцыг хадгалах үүрэг нь хэвээр үргэлжилнэ.

7.2 Холбооны Удирдах зөвлөл болон түүний дэргэдэх зөвлөлүүд, ажлын хэсгүүдийн хурлын яриа хэлэлцүүлэг нууц байна. Үйлчлэлд хамаарах этгээд нь энэхүү нууцыг Ерөнхийлөгчийн болон Ерөнхий нарийн бичгийн даргын бичгээр өгсөн зөвшөөрлөөс бусад тохиолдолд бүхэлд нь болон хэсэгчлэн гуравдагч этгээдэд задруулахыг хориглоно.



Тайлбар: Энэхүү нууцад хурлын тэмдэглэл болон дагалдан гарсан баримт бичгүүд, уулзалтын үеэрх хэлэлцүүлгийн агуулга (хэвлэгдсэнээс бусад тохиолдолд) зэрэг хамаарна.

НАЙМ. ТӨВИЙГ САХИХ ҮҮРЭГ

8.1 Үйлчлэлд хамаарах этгээд нь Засгийн газар, Үндэсний болон олон улсын байгуулага, холбоодтой харилцахдаа Засгийн газрын болон улс төрийн үйл ажиллагаанаас ангид байх Олимпизмын зарчмуудыг баримтлана.

ЕС. АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС АНГИД БАЙХ ҮҮРЭГ

9.1 Албан тушаалтнууд нь усан спортын ашиг сонирхлыг эрхэмлэн дээдэлж, аливаа шийдвэр гаргах үйл ажиллагаанд бусдын нөлөөнд авталгүй, өөрийн бодит үнэлэлт дүгнэлтэнд суурьласан, бие даасан шийдвэрийг гаргаж оролцоно.

9.2 Албан тушаалтнууд нь өөрийн болон түүний хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхол нь МУССХ-ны аливаа үйл ажиллагаа, шийдвэрт ашиг сонирхлын зөрчилтэй байх нөхцөл үүсвэл энэ талаархи үнэн зөв, бүрэн гүйцэд мэдээллийг Ёс зүйн зөвлөлд өгч, тухайн асуудалд оролцохоос зайлсхийх үүргийг хүлээнэ.

9.3 Албан тушаалтнууд нь ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой аливаа мэдээллийг Ёс зүйн зөвлөлөөс бэлтгэсэн маягыг ашиглан өгөх бөгөөд тухайн асуудлаархи шинэ баримт, нөхцөл байдлын талаар үргэлжлүүлэн мэдээлэх үүрэгтэй. Ёс зүйн зөвлөл нь ашиг сонирхлын зөрчлийн талаархи аливаа мэдээллийг Ашиг сонирхлын зөрчлийн тэмдэглэлд бүртгэж авна.

9.4 Албан хаагчид нь аливаа хурлын үед үүссэн ашиг сонирхлын зөрчлийн тохиолдолд, энэ талаар Ёс зүйн зөвлөлийн дарга, гишүүд мөн тухайн хурлыг даргалагчид мэдэгдэнэ (ашиг сонирхлын зөрчлийн тэмдэглэлд өмнө нь тэмдэглэгдсэн эсэхээс үл хамаарна). Ёс зүйн зөвлөлийн дарга, гишүүд эсвэл хурал даргалагч нь:

- а) Ашиг сонирхлын зөрчлийн талаар хуралд оролцогчдод мэдэгдэнэ
- б) Өмнө нь бүртгэгдээгүй шинэ мэдээллийг ашиг сонирхлын зөрчлийн тэмдэглэлд бүртгэж авна. Мөн хурлын тэмдэглэлд тэмдэглүүлнэ.

9.5 Ашиг сонирхлын зөрчилтэй албан тушаалтан нь Ёс зүйн зөвлөлийн дарга болон Хурал даргалагч хоёулаа зөвшөөрснөөс бусад тохиолдолд:

- а) Ашиг сонирхлын зөрчилтэй аливаа асуудлаар хэлэлцүүлэгт оролцохгүй байх
- б) Тухайн асуудлаар явагдах аливаа санал хураалтанд оролцохоос түтгэлзэх
- в) Тухайн асуудлыг шийдвэрлэх үйл явцад оролцохоос зайлсхийх үүрэгтэй



9.6 Ёс зүйн зөвлөлийн дарга болон хурал даргалагч хоёулаа ашиг сонирхлын зөрчил бүхий албан хаагч нь тухайн шийдвэрээс санхүүгийн болон бусад төрлийн ашиг хонжоо олохгүй нь баталгаатай гэж үзвэл түүнийг дүрмийн 9 зүйлд заасан аливаа шаардлагаас чөлөөлж болно.

9.7 Дүрмийн 9 зүйлд заасан шаардлагаас чөлөөлсөн тухай мэдээллийг Ашиг сонирхлын зөрчлийн тэмдэглэл болон тухайн хурлын тэмдэглэлд тэмдэглэнэ.

9.8 Албан тушаалтнууд нь МУССХ болон МУССХ-ны гишүүд, бусад хамтран ажилладаг этгээдүүдийн хоорондын харилцаанд ямар нэг ашиг сонирхлын зөрчилтэй бол түүнийгээ мэдэгдэх үүрэгтэй. Ийм ашиг сонирхлын зөрчлийг дүрмийн 9 зүйлд заасан шаардлагаас чөлөөлөхгүй. Албан тушаалтнууд нь энэ асуудлаар доорхи үүргийг хүлээнэ.

а) Ямар нэг тодорхой байгууллага (жишээ: МУССХ-ны гишүүн байгууллага, клуб) болон гуравдагч этгээдийн асуудлыг авч хэлэлцэхдээ тэдний ашиг сонирхлыг бус зөвхөн МУССХ болон усан спортын өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа ухамсарлан ажиллах.

б) МУССХ-ны өмнө хүлээсэн үүрэг, хариуцлагатай нь зөрчилдөх үйлдэл хийх, хийхээр зөвшөөрөх эсвэл бусдын нөлөөнд автах зэрэг ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх. (жишээ нь: тодорхой асуудлаар санал өгөхөөр тохиролцох)

в) Ёс зүйн зөвлөлийн дарга, гишүүдийн хүсэлтийн дагуу тэдний шийдвэрт нөлөөлж болзошгүй аливаа нэмэлт мэдээлэл байгаа бол гаргаж өгөх.

9.9 Үйлчлэлд хамаарах этгээд МУССХ-ны албан тушаал, эрх мэдлээ хэн нэгний болон өөрийн зорилго, ашиг сонирхлын төлөө урвуулан ашиглах ёсгүй.

9.10 МУССХ-ны албан тушаалтнууд ажил үүргээ хэрэгжүүлэх үедээ болон холбоог төлөөлөн гадаад дотоодын үйл ажиллагаанд оролцохдоо хүний эрх, эрх чөлөөг дээдэлж, ёс суртахууны нийтлэг хэм хэмжээг даган мөрдөж, усан спорт болон холбооны нэр хүндийг өндөрт өргөж аливаа ашиг сонирхлын зөрчил болон нөлөөллөөс ангид байх үүрэгтэй.

АРАВ. ХӨРӨНГӨ МӨНГИЙГ ХУВЬДАА АШИГЛАХ, ХУУРАН МЭХЛЭХ

10.1 Үйлчлэлд хамаарах этгээд баримт бичгийн эх хувийг нуун дарагдуулах, хуурамчаар үйлдэх, мэдсээр байж хуурамч баримтыг санаатайгаар ашиглахыг хориглоно.

10.2 Үйлчлэлд хамаарах этгээд нь төрсөн он, сар, өдөр, үндэс угсаа, амжилт болон сонгуулийн үр дүнг санаатайгаар худал мэдээлэхийг хориглоно.

10.3 Үйлчлэлд хамаарах этгээд нь холбооны шийдвэр болон үйл ажиллагаанд нөлөөлөх, аливаа гэрээ хэлэлцээр, бизнесийн үйл ажиллагаанд бусдад давуу байдал олгох зорилгоор шууд болон шууд бусаар хөрөнгө мөнгө өгөх, өгөхөөр амлах, гэрээний үнийн дүнгийн хэсгийг санал болгох, ажилдаа хайнга хандах, эс үйлдэх зэргийг хориглоно.



10.4 Үйлчлэлд хамаарах этгээд нь хөрөнгө мөнгийг зориулалтын бусаар зарцуулах, хувьдаа ашиглах, өөрийн ажил үүргээс гардуур бусадтай хөрөнгө мөнгөний харилцаанд орохыг хориглоно. Зөвхөн хууль ёсны дагуу, бодит эх үүсвэрээс орж ирсэн буюу бий болсон хөрөнгө мөнгийг л холбооны үйл ажиллагааг санхүүжүүлэхэд ашиглана.

10.5 Үйлчлэлд хамаарах этгээд нь зөвхөн холбооны үйл ажиллагаанд зориулсан тодорхой зардлыг зохих журмын дагуу нэхэмжилж болно. Төлөгдөөгүй төлбөрийн үлдэгдлийг цуцлах эсвэл хариуд нь давуу байдал олгохыг эсвэл хүсэхийг хатуу хориглоно.

АРВАН НЭГ. БЭЛЭГ ӨГӨХ, БЭЛЭГ АВАХ

11.1 Үйлчлэлд хамаарах этгээд доорхи зүйлсийг санал болгох, эсвэл хүлээн авахыг хориглоно:

- а) Мөнгөн бэлэг эсвэл хахууль авах, өгөх
- б) Дайлуулах, бэлэг авах, ямар нэг ашиг тус, давуу байдлыг өөртөө нууцаар бий болгох
- в) Албаны эрх үүргээ хэрэгжүүлэхэд нь нөлөөлж, шийдвэр гаргалтанд нь ашиг сонирхолоо тусгах зорилгоор бэлэг сэлт өгөх, дайлах, ямар нэгэн ашиг тус санал болгохыг (жишээлбэл: нэр дэвшиж буй этгээд санал өгөх талд бэлэг өгөх)
- г) Усан спортын нэр хүндийг унагаж, хүлээн авагчийг ёс зүйн дүрмийн зөрчилд хүргэж болзошгүй дайллага, бэлэг сэлт, ямар нэг ашиг тусыг хүлээн авахыг

11.2 Үйлчлэлд байгаа этгээд нь дүрмийн 11.1 заалтанд харшлахгүйгээр доорхи зүйлсийг санал болгох, эсвэл хүлээн авч болно.

- а) Орон нутгийн зан заншлийн дагуу нөхөрлөл, хамтын ажиллагааг бэлгэдсэн, дурсгалын зүйлсийг
- б) Нөхөрлөл, хамтын ажиллагааны бодит байдалд нийцсэн бэлэг, зочломтгой байдлыг (жишээ нь: үйл ажиллагааны урилга эсвэл тасалбар)

Тайлбар: Дээрхи бэлэг дурсгалын зүйлсийн үнийн дүн 100,000 төгрөгөөс хэтэрч болохгүй бөгөөд хэтэрсэн тохиолдолд бэлэг хүлээн авагч нь Ёс зүйн зөвлөлийн даргад мэдэгдэх үүрэгтэй. Ёс зүйн зөвлөлийн дарга тухайн бэлгийг бэлэг хүлээн авагчид үлдээх эсэхийг шийдвэрлэх бөгөөд эс зөвшөөрсөн тохиолдолд тухайн бэлгийг холбооны сан хөмрөгт бүртгэж авна.

АРВАН ХОЁР. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ, ТЕНДЕР

12.1 МУССХ-ны арга хэмжээг зохион байгуулах болон төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалтын ажилд саналаа өгч өрсөлдөж байгаа байгууллагууд, түүний ажилтан албан хаагчид, зохион байгуулагчид, сайн дурынхан, төлөөлөн оролцох эрх бүхий бусад этгээдүүд Монгол улсын хууль тогтоомж болон МУССХ-ны дүрэм, Ёс зүйн дүрмийн хүрээнд шударгаар, өрсөлдөгчдөө хүндэтгэлтэй хандаж оролцоно.



Мөн доорхи шаардлагыг ханган ажиллана:

- а) МУССХ-ны сонгон шалгаруулалт, тендерийн үйл ажиллагаанд хүндэтгэлтэй хандана.
- б) МУССХ-ны албан хаагчид болон ивээн тэтгэгчид, хамтран ажилладаг байгууллага, хувь хүмүүсээс үндэслэлгүй дэмжлэг туслалцаа хүсэхгүй байх.
- в) Сонгон шалгаруулалт, тендерийн бусад оролцогчдын төсөлтэй өөрийн төсөл хөтөлбөрийг урьдчилан харьцуулж үзэхгүй байх.
- г) Сонгон шалгаруулалт, тендерийн бусад оролцогчидтой үгсэн хуйвалдах, тохиролцоо хийх, хамтран ажиллахаар гэрээ байгуулахгүй байх.
- д) Сонгон шалгаруулалтын ажил дуусаагүй байхад МУССХ-ны эрх бүхий албан тушаалтан, тендерийн ажилтны байр, унаа, хоол зэрэг аялалын зардлыг хариуцан төлөхгүй байх.

Тайлбар: МУССХ нь сонгон шалгаруулалттай холбоотой нэмэлт материал, мөн гуравдагч этгээдээс авсан санхүүгийн болон бусад төрлийн туслалцааны талаархи мэдээллийг бүх оролцогчдоос шаардаж болно.

12.2 Үйлчлэлд хамаарах этгээд нь доорхи үүргийг хүлээнэ:

- а) Сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг шударгаар явуулах, бүх өрсөлдөгчдийг ижил тэгш боломж нөхцлөөр хангах, тэдэнд хүндэтгэлтэй хандах.
- б) Сонгон шалгаруулалтын явцад аль нэг оролцогчид давуу байдал олгохыг шууд болон шууд бусаар ятгах эсвэл зөвшөөрөх.
- в) МУССХ-ны мэдээлэл болон хөрөнгө мөнгөний эх үүсвэрээр аль нэг оролцогчийг онцгойлон хангахгүй байх.
- г) Оролцогчдын сонгон шалгаруулалтад чөлөөтэй, нээлттэй оролцох эрхийг хүндэтгэж, олон нийтэд аль нэг оролцогчийн талаар онцгойлон мэдээлэл хийхгүй байх.

12.3 Зөвхөн МУССХ-ны Ерөнхийлөгч, Ерөнхий нарийн бичгийн дарга эсвэл тэднээс албан ёсоор төлөөлөх эрхийг авсан этгээд Сонгон шалгаруулалтын талаархи зар, мэдээлэл, албан захидлын харилцааг эрхлэн гүйцэтгэнэ.

АРВАН ГУРАВ. СОНГУУЛЬ

13.1 МУССХ-ны албан тушаалд нэр дэвшигчид болон тэднийг туслан дэмжигчид нь Монгол улсын хууль тогтоомж, МУССХ-ны дүрэм, журам болон Ёс зүйн дүрмийн хүрээнд бусад нэр дэвшигчдэд хүндэтгэлтэй хандаж, шударгаар өрсөлдөнө.

Тайлбар: Нэр дэвшигч гэж МУССХ-ны сонгуулийн комисст нэр дэвших хүсэлтээ албан ёсоор гаргасан хүнийг хэлнэ. Нэр дэвших хүсэлтээ албан ёсоор хүргүүлээгүй байгаа ч нэр дэвшигчийн хувиар олон нийтийн өмнө ямар нэг үйл ажиллагаа явуулсан этгээд ч МУССХ болон Ёс зүйн



дүрмийн үйлчлэлд хамаарагдана.

13.2 Нэр дэвшигч нь өөрийн үзэл бодол, зорилго, хэрэгжүүлэх ажлын талаархи мөрийн хөтөлбөрийг бичгээр бэлтгэж сонгогчдод хүргүүлж болно. Нэр дэвшигч нь сурталчилгаандаа ашигласан бүх баримт бичгүүдийн хуулбарыг Ёс зүйн зөвлөлд хүргүүлэх бөгөөд Ёс зүйн зөвлөл яаралтай танилцаж зөрчилтэй агуулга байгаа эсэхийг хянана.

13.3 Нэр дэвшигчид хэвлэл мэдээллийн хэрэгсэлд мэдээлэл, ярилцлага өгч болно. Энэ үеэр бусад нэр дэвшигчдээ хүндэтгэж, тэдний нэр хүнд, ашиг сонирхлын эсрэг үйлдэл гаргахыг хатуу хориглоно.

13.4 Нэр дэвшигчдэд доорхи зүйлсийг хориглоно.

а) Сонгогдсон тохиолдолд өөрийн шийдвэр гаргах эрх чөлөөнд нөлөөлж болох аливаа хувь хүн, байгууллагад ямар нэг хэлбэрийн амлалт өгөхийг

б) Санал хураалтын үр дүнг өөрчлөх, зүй бусаар ашиглах, хуурч мэхлэх зорилгоор бусад нэр дэвшигчидтэй үгсэн хуйвалдах, хамтран ажиллахыг

в) МУССХ-н дахь холбоо хамаарлаа ашиглан ямар нэгэн дэмжлэг туслалцаа, үйлчилгээг авах, авахыг хүсэхийг хориглоно. Нэр дэвшигч тухайн үед МУССХ-нд ямар нэгэн ажил, албан тушаалтай, эсвэл сонгуульт ажил эрхэлдэг байсан ч энэ заалтыг мөрдөнө.

13.5 Үйлчлэлд хамаарах этгээд болон сонгууль өгөх төлөөлөгч нь доорхи үүрэгтэй:

а) Нэр дэвшүүлэх үйл явцыг хүндэтгэн ёс зүйтэй хандах, бүх нэр дэвшигчдэд ижил тэгш нөхцөл бололцоо олгож, тэдэнтэй адил тэгш харилцах, ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдлээс сэргийлэх.

б) Нэр дэвшигчээс ёс зүйн дүрмээр зөвшөөрөгдөөгүй бэлэг болон зочломтгой байдлыг ямар нэг байдлаар хүлээж авахгүй байх.

в) Нэр дэвшигчээс шууд болон шууд бусаар аливаа хэлбэрийн давуу талыг өөртөө бий болгохыг шаардахгүй байх.

г) Ямар нэгэн нэр дэвшигчид туслах, дэмжих зорилгоор МУССХ-ны нөөц бололцоог ашиглахгүй байх.

АРВАН ДӨРӨВ. ЁС ЗҮЙН ДҮРМИЙН СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА

14.1 МУССХ нь өөрийн зохион байгуулах бүх төрлийн арга хэмжээнд оролцох тамирчид, дасгалжуулагчид, албаны хүмүүс, дэмжин туслагчдыг ёс зүйн дүрмийн цахим болон биечилсэн сургалтанд хамрагдахыг шаардаж болно.

14.2 Энэхүү шаардлагыг хангаагүй аливаа тамирчин, дасгалжуулагч, дэмжин туслагчид шаардлагыг биелүүлэх хүртлээ МУССХ-ны арга хэмжээнд оролцох эрхгүй.



ГУРАВ ДУГААР БҮЛЭГ – ХУУРАН МЭХЛЭЛТ, ТҮҮНЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

АРВАН ТАВ. АВЛИГЫН ЭСРЭГ ДҮРЭМ

15.1 Үйлчлэлд хамаарах этгээдийн гаргасан доорхи үйлдлүүдийг шууд болон шууд бус гэх мэт оролцсон байдлаас нь үл хамааран ёс зүйн зөрчил гэж үзнэ.

а) Усан спортын бүх төрлийн арга хэмжээнд бооцоо тавих. Тухайн арга хэмжээнд биечлэн оролцсон оролцоогүйгээс үл хамаарна.

б) Өөрийн биеэр оролцож байгаа усан спортын төрөл багтсан спортын арга хэмжээний үеэр бооцоо тавих. Жишээ нь: Олимпийн наадамд оролцож байгаа тамирчин болон туслан дэмжигчид өөр ямар нэг спортын төрлийн тэмцээнд бооцоо тавих.

в) Хуурч мэхлэх, авлига өгөх, авлига авах замаар аливаа арга хэмжээ, тэмцээн уралдааны үеэр өөртөө давуу байдал ашиг хонжоо олохыг. Үүнд:

- Арга хэмжээний зохион байгуулалт, үр дүнг ямар нэгэн байдлаар засах, хуурамчаар зохиох, эсхүл зохисгүй байдлаар нөлөөлөх.

- Үйлчлэлд хамаарах этгээд нь ажил үүргийн шугмаар олж авсан, арга хэмжээний үр дүнгийн талаархи аливаа мэдээллийг, бусадтай хамтран ашиг олох зорилгоор ашиглах.

- Бусдын нөлөө ятгалганд орж эсвэл ямар нэг ашиг хонжоо олох (ашиг хонжоо олсон, олоогүйгээс үл хамаарна) зорилгоор тэмцээний үеэр өөрийн үр чадвар, нөөц боломжийг бүрэн дайчлахгүй байх.

- Арга хэмжээний үр дүнг засах, хуурамчаар зохиох, эсхүл зохисгүй байдлаар нөлөөлөх замаар ашиг хонжоо олох зорилгоор хахууль (бодитоор хүлээн авсан, аваагүйгээс үл хамааран) санал болгох, эсвэл хүлээн авахыг

г) Дотоод мэдээллийг задруулах. Үүнд:

- Үйлчлэлд хамаарах этгээд нь дотоод мэдээллийг бооцоо тавих, арга хэмжээний үр дүнд нөлөөлөх болон бусад хорт зорилгоор өөрөө болон бусдаар дамжуулан ашиглахыг

- Дотоод мэдээллийг бооцоо тавих, арга хэмжээний үр дүнд нөлөөлөх болон бусад хорт зорилгоор ашиглахыг нь мэдсээр байж, эсвэл мэдэх боломжтой атлаа бусад хувь хүн, байгууллагад задруулахыг (энэхүү үйлдлээсээ ашиг хонжоо олсон олоогүйгээс үл хамаарна)

- Дотоод мэдээллийг задруулсны төлөө шан харамж амлах/ авахыг (бодитоор дотоод мэдээллийг задруулсан эсэхээс үл хамаарна)

д) Ёс зүйн дүрмэнд тусгагдаагүй ч Монгол улсын хууль тогтоомж, дүрэм журмыг зөрчсөн болон усан спортын нэр хүндийг олон нийтийн дунд унагаах үйлдлийг



15.2 Энэ зүйлийн Ёс зүйн зөрчлийг шийдвэрлэхэд доорхи нөхцлүүд нөлөөлөхгүй.

- а) Үйлчлэлд хамаарах этгээд нь зөрчил үүссэн арга хэмжээнд өөрөө эсвэл тамирчныг туслан дэмжиж оролцсон эсэх нь
- б) Бооцоо тавьсан арга хэмжээний үр дүн ямар байдлаар гарах нь
- в) Мөнгө болон ашиг хонжоог бодитоор олгосон эсвэл хүлээн авсан эсэх нь
- г) Тавигдсан бооцооны мөн чанар, үр дүн ямар байх нь
- д) Үйлчлэлд хамаарах этгээдийн зөрчил үүссэн арга хэмжээнд оролцсон оролцооны байдал, гүйцэтгэл, хүчин чармайлт, үйлдэл, эс үйлдэл нь
- е) Үйл ажиллагааг будилаантуулах, хууран мэхлэх болон техникийн үйл ажиллагааны зөрчил гарсан тухайн арга хэмжээг ямар байгууллага зохион байгуулж байгаа нь
- г) Тухайн арга хэмжээнд МУУСХ болон Тив, Дэлхийн усан спортын холбоо, бусад спортын байгууллагуудын төлөөлөгчид оролцож байгаа эсэх нь

АРВАН ЗУРГАА. БООЦООНЫ БАЙГУУЛЛАГАТАЙ ХОЛБООТОЙ ХАРИЛЦАА

16.1 Үйлчлэлд хамаарах этгээд нь ямар нэг бооцоот болон мөрийтэй тоглоомын бизнесийн үйл ажиллагаа эрхлэх, эсвэл зөвөлгөө мэдээлэл өгөх, хувь эзэмших, хамтран ажиллахаар тохиролцох, шууд болон шууд бусаар үйл ажиллагаанд нь оролцохыг хориглоно.

16.2 Үйлчлэлд хамаарах этгээд нь хэрэв бооцоот тоглоомын бизнес эрхэлдэг охин компаний толгой компанид ажилладаг бол доорхи нөхцлүүдийг баталсан тохиолдолд энэхүү дүрмийн 16.1 заалтын дагуу ёс зүйн зөрчилд тооцохгүй.

- Бооцоот тоглоомын бизнесийн үйл ажиллагаа явуулдаг охин компаний үйл ажиллагаанд шууд байдлаар оролцдоггүй байх
- Бооцоот тоглоомын бизнесийн үйл ажиллагаа явуулдаг охин компаниас шууд болон шууд бусаар ямар нэгэн ашиг хүртдэггүй байх
- Толгой компани ямар нэгэн бооцоот тоглоомын бизнес эрхэлдэггүй байх

16.3 Үйлчлэлд хамаарах этгээдийн ойрын гэр бүлийн гишүүн (гэр бүлийн хүн/ хамтрагч, эцэг эх, ах эгч, хүүхэд) нь Бооцоот тоглоомын бизнестэй, ойрын харилцаа холбоотой эсвэл өдөр тутмынх нь үйл ажиллагаанд оролцдог бол Ёс зүйн зөвлөлд урьдчилан мэдэгдэж, бүртгүүлсэн, зөвшөөрөл авснаас бусад тохиолдолд дүрмийн 15.1 зүйлд заасан зөрчлийг гаргасан гэж үзнэ.



ДӨРӨВ ДҮГЭЭР БҮЛЭГ – ЁС ЗҮЙН ДҮРМИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

АРВАН ДОЛОО. МУССХ-НЫ ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛ

17.1 МУССХ-ны Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хянаж, дагаж мөрдүүлэх, болзошгүй ёс зүйн зөрчлийг шалгах, буруутай этгээдэд хариуцлага тооцох үүргийг МУССХ-ны Удирдах зөвлөлийн дэргэдэх Ёс зүйн зөвлөл хариуцна.

17.2 Ёс зүйн зөвлөл чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллахад доорхи бүтэц нэгжүүд туслан, дэмжиж ажиллана. Үүнд:

- а) Ёс зүйн зөвлөлийн дарга, түүний гишүүд
- б) Сургалт сурталчилгааны баг (сэргээшийн эсрэг асуудлаар)
- в) Шаардлагатай тохиолдолд МУССХ-ны албан хаагчид

17.3 Ёс зүйн зөвлөл нь өөрийн ажлын байртай байж болох бөгөөд ёс зүйн зөвлөлийн гишүүдийн болон бичиг баримтын аюулгүй байдлыг сайтар хангасан байна. МУССХ-ны байранд албан өрөөтэй бол холбооны албан хаагчид болон Ёс зүйн зөвлөлийн гишүүдийн хооронд ашиг сонирхлын зөрчил үүсэхээс сэргийлж, хэн ч зөвшөөрөлгүй нэвтрэх боломжгүй байх ёстой.

17.4 Шаардлагатай тохиолдолд Ёс зүйн зөвлөл нь МУССХ-ны нөөц боломж, албан хаагчдын үзүүлж буй үйлчилгээг ашиглаж болох бөгөөд энэ нь зөвлөлийн бие даасан, хараат бусаар үйл ажиллагаагаа явуулахад нь нөлөөлөхөөргүй байна. Харин МУССХ-ны албан тушаалтантай холбоотой Ёс зүйн зөрчлийн шалгалтын явцад дээрхи харилцааг бүрэн хориглоно.

17.5 Ёс зүйн зөвлөлийн гишүүд нь МУССХ-нд харьяалагдах хэдий ч өөрийн үйл ажиллагааг зөвхөн Удирдах зөвлөлд л тайлагнана.

17.6 МУССХ-ны Удирдах зөвлөл нь Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинээр баталсан мөчөөс эхлэн өмнөх Ёс зүйн зөвлөлийн бүрэн эрх дуусгавар болно. Ёс зүйн зөвлөлийн гишүүнийг өөрийн хүсэлтээр болон Удирдах зөвлөлийн шийдвэрээр хугацаанаас нь өмнө чөлөөлж болно. Ийм тохиолдолд Удирдах зөвлөл тухайн гишүүнийг нөхөж шинэ гишүүнийг томилно.

17.7 Ёс зүйн зөвлөлийг чиг үүргээ хэрэгжүүлэхэд зориулан МУССХ-ны Удирдах зөвлөл төсөв хуваарьлах, гарсан зардлыг нь нөхөн төлөх асуудлыг шийдвэрлэж болно.

АРВАН НАЙМ. ХЯНАЛТ

Ёс зүйн зөвлөл нь өөрийн бүхий л нөөц боломжинд тулгуурлан Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, болзошгүй зөрчлийг шалган шийдвэрлэхийн тулд доорхи ажлуудыг хийнэ. Үүнд:

- а) Гуравдагч этгээдээс ирүүлж болох мэдээллийг хүлээн авах сувгийг бий болгох (утасны дугаар, цахим хаяг г.м)



- б) Хууль тогтоомж болон Ёс зүйн дүрмийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах, мэдээлэл солилцох, хариуцлага тооцох чиглэлээр Үндэсний болон дэлхий, бүс нутгийн усан спортын болон бусад эрх бүхий байгууллагуудтай үр дүнтэй харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх
- в) Бусад спортын байгууллагуудтай авлигын талаар мэдээлэл солилцох
- г) Ёс зүйн дүрэм болон зөрчлийн талаар сургалт, сурталчилгааны ажлыг гүйцэтгэх
- д) Мөрийтэй холбоотой болзошгүй эрсдлийг үнэлэх, түүнд хяналт тавих

АРВАН ЕС. МЭДЭЭЛЭХ

- 19.1 Ямар ч хүн ёс зүйн болзошгүй зөрчлийн талаархи мэдээллийг Ёс зүйн зөвлөлд өгч болно.
- 19.2 Зөрчилд тооцогдож болох аливаа үйлдэл, хандлага, хүсэлт зэрэг ёс зүйн болзошгүй зөрчлийн талаархи бүх гомдол мэдээллийг Ёс зүйн зөвлөл бүртгэн хүлээж авна.
- 19.3 Ёс зүйн зөвлөлд гомдол мэдээллийг өгсөн этгээд нь шалгах ажиллагаанд оролцох, шалгах ажиллагааны талаар болон гарсан шийдвэрийн талаар мэдээлэл хийх эрхгүй. Ёс зүйн зөвлөл зөрчлийн үйлдэлд буруутгагдсан хүнээс тодруулга тайлбар авах, авагдсан мэдээллийг нягтлах, шалган шийдвэрлэх ажиллагааг цаг алдалгүй явуулна. Ёс зүйн зөвлөл нь зөрчлийг хянан шийдвэрлэх явцдаа хоёр талын байр суурь, эрх ашгийг адил тэнцүү авч үзэх бөгөөд мэдээллээр ижил түвшинд ханган ажиллана.
- 19.4 Энэхүү Ёс зүйн дүрмийн дагуу зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэх бүрэлдэхүүнээс гаргасан шийдвэр нь Ёс зүйн зөвлөлийн шийдвэр гэж тооцогдоно.

ХОРЬ. ЗӨРЧЛИЙГ ШИЙДВЭРЛЭХ

- 20.1 Юуны өмнө Ёс зүйн зөвлөл нь тухайн гомдол мэдээллийг ёс зүйн зөрчил мөн эсэхийг тодорхойлно. Ёс зүйн зөвлөл нь ёс зүйн дүрмийн нэг болон түүнээс олон заалтыг зөрчсөн гэх хангалттай баримт байгаа эсэх, тухайн зөрчлийг ирсэн гомдол мэдээллийн хүрээнд шийдвэрлэх боломжтой эсэх талаархи урьдчилсан дүгнэлтийг гаргана. Ёс зүйн зөвлөл нь ёс зүйн дүрмийн нэг болон түүнээс олон заалтыг зөрчсөн гэх хангалттай баримт байхгүй эсвэл Ёс зүйн зөвлөлийн чиг үүрэгт хамаарахгүй гэж үзвэл шалгалтын ажиллагаа явуулахаас татгалзах эрхтэй. Талууд энэ шийдвэрийг давж заалдах эрхгүй.
- 20.2 Хэрэв Ёс зүйн зөвлөл нь ёс зүйн дүрмийн болзошгүй зөрчил мөн байна гэж үзвэл гомдол мэдээлэл гаргагчаас шийдвэр гаргахад нь туслах нэмэлт мэдээлэл, нотлох баримтыг хүсч болно.
- 20.3 Хэрэв Ёс зүйн зөвлөл нь анхны болон нэмэлтээр ирүүлсэн нотлох баримтууд нь хангалттай байна гэж үзвэл ёс зүйн болзошгүй зөрчлийн шалгалтын ажиллагааг эхлүүлнэ.
- 20.4 Ёс зүйн зөвлөл нь ирсэн гомдол мэдээллийн дотроос өөрийн анхаарлыг татсан ямар ч мэдээллийг



ашиглан ёс зүйн болзошгүй зөрчлийн шалгалтын ажиллагааг эхлүүлэх шийдвэрийг гаргаж болно.

20.5 Ёс зүйн зөвлөл нь болзошгүй зөрчлийн шалгалтын ажиллагааны талаар ямар нэгэн тайлбар өгөх шаардлагагүй бөгөөд зөвлөлийн шийдвэрийг эсэргүүцэн маргахгүй. Хариуцагч этгээдэд болзошгүй ёс зүйн зөрчил болон түүнтэй холбоотой шалгалтын ажиллагаа эхэлсэн тухай мэдэгдэж, шалгалтын ажилд зориулан бичгээр тайлбар мэдээлэл өгөх эрхээр хангана.

20.6 Ёс зүйн зөвлөл нь ёс зүйн зөрчил нь эхний байдлаар нотлогдож байгаа хариуцагчид ёс зүйн зөрчлөө хүлээн зөвшөөрч тохирсон шийтгэлээ хүлээхийг сануулсан захидал бичиж болно. Хариуцагч зөрчлөө хүлээн зөвшөөрвөл Ёс зүйн зөвлөл нь тухайн зөрчилд тохирсон шийтгэлийг оногдуулж шийдвэрлэнэ.

20.7 Ёс зүйн зөрчлийг шалгах явцад цугласан баримтууд нь асуудлыг ёс зүйн дүрмийн хүрээнд биш эрх бүхий байгууллагуудын оролцоотойгоор шийдвэрлэх ёстой гэж үзвэл холбогдох байгууллагуудад шилжүүлэн шийдвэрлэнэ.

20.8 МУССХ-ны Ёс зүйн зөвлөл нь аливаа зөрчлийг өөрийн Ёс зүйн дүрмийн хүрээнд шийдвэрлэх боломжгүй, чадамжгүй байдалд хүрвэл Дэлхийн Усан спортын холбоо буюу World Aquatics- ын Ёс зүйн дүрэм (Integrity Code)- ийн хүрээнд шийдвэрлүүлнэ.

ХОРИН НЭГ. ТҮР ТҮТГЭЛЗҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

21.1 Ёс зүйн зөвлөл нь болзошгүй ёс зүйн зөрчлийн шалгалтын ажил дуусч, шийдвэр эцэслэн гарах хүртэл хариуцагчийн аюулгүй байдал болон олон нийтийн дунд усан спортын нэр хүндийг унахаас сэргийлж түр түтгэлзүүлэх арга хэмжээг авч болно. Түр түтгэлзүүлэх арга хэмжээг авахаас өмнө хариуцагч өөрийн байр суурийг илэрхийлэх боломжгүй. Ёс зүйн зөвлөлийн шийдвэр гарсан мөчөөс эхлэн түр түтгэлзүүлэх арга хэмжээ хэрэгжиж эхэлнэ. Хариуцагчид түр түтгэлзүүлэх арга хэмжээ авсан тухай шийдвэрийн хуулбарыг:

- а) Хариуцагч болон түүний харьяалагддаг Холбооны гишүүн байгууллага, клубт хүргүүлнэ
- б) Олон нийтэд зарлана

21.2 Түр түтгэлзүүлэх арга хэмжээ авсан тухай шийдвэрийг давж заалдахгүй.

21.3 Хариуцагч нь түр түтгэлзүүлсэн хугацаанд дүрмийн 33.8 зүйлд заасантай ижил хориг хязгаарлалтыг дагаж мөрдөнө.

21.4 Хариуцагч нь өөрийнх нь эсрэг үүсгэсэн зөрчлийн шалгалтын ажиллагааг шийдвэрлэгдэж дуусах хүртэл сайн дураараа түтгэлзэж болно. Энэ тохиолдолд хариуцагч нь түтгэлзэх хүсэлтээ Ёс зүйн зөвлөлд бичгээр хүргүүлсэн мөчөөс хориг хязгаарлалт хэрэгжиж эхэлнэ.

21.5 Хариуцагчийн сайн дураараа түтгэлзэх хүсэлтэнд сөрөг дүгнэлт гаргахыг хориглох бөгөөд хэн нэгний зөвшөөрөл шаардлагагүй шууд хүлээн авна.



21.6 Хариуцагч ёс зүйн зөрчлийн үйлдэл гаргасан нь тогтоогдвол түүний түр түтгэлзсэн хугацааг (сайн дураар эсвэл бусад хэлбэрээр гэдгээс үл шалтгаална) оноосон эрх хасах шийтгэлийн хугацаанаас хасаж тооцно.

ХОРИН ХОЁР. ЁС ЗҮЙН ДҮРМИЙН БОЛЗОШГҮЙ ЗӨРЧЛИЙГ ШАЛГАХ

22.1 Ёс зүйн зөвлөлийн дарга нь зөвлөлийн нэг гишүүнийг томилж ёс зүйн дүрмийн болзошгүй зөрчлийг шалгана

22.2 Ёс зүйн зөвлөл болон гишүүд нь МУССХ-ны албан хаагчдын тусламжийг авч болно.

22.3 Ёс зүйн зөвлөл нь болзошгүй ёс зүйн зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагааны аль ч шатанд (шийтгэл ноогдуулсны дараа ч) бодит үнэнийг тогтооход шаардлагатай нэмэлт баримт, нотолгоо гаргаж өгөх шаардлагыг хариуцагчид бичгээр гаргаж болно.

22.4 Хариуцагч нь уг шаардлагыг биелүүлээгүй эсвэл биелүүлэхээс татгалзсан тохиолдолд Ёс зүйн дүрмийн 6 дугаар зүйлийн "Зөрчлийн мөрдөн шалгалтын явцад шаардлагатай баримт мэдээллийг нуун дарагдуулах, устгах болон устгахыг оролдох зэргээр саад учруулах нь Ёс зүйн дүрмийн зөрчилд хамаарна" гэсэн заалтыг үндэслэн ёс зүйн зөрчил гаргасанд тооцно.

22.5 Ёс зүйн зөвлөл нь ёс зүйн дүрмийн болзошгүй зөрчлийг шалгах эсэх, шалгах бол шийдвэр гарах хүртэл хариуцагчид түр түтгэлзүүлэх арга хэмжээ авах эсэх шийдвэрийг гаргаж шалгалтын ажиллагааг явуулна.

22.6 Тамирчидтай холбоотой асуудлыг дасгалжуулагч болон асран хамгаалагчийг байлцуулан шийдэх бөгөөд онц ноцтой биш бол тэмцээнд оролцож буй тамирчны сэтгэл зүйд нөлөөлж амжилтанд сөргөөр нөлөөлөхгүй байх зорилгоор шалгалтын ажиллагааг хойшлуулж болно.

22.7 Ёс зүйн зөвлөл шалгалтын ажиллагааг үргэлжлүүлэн явуулахгүй байх шийдвэр гаргасан бол бүх шалгалтын ажлыг зогсоож, өмнө нь авсан түр түтгэлзүүлэх арга хэмжээг цуцална. Талууд энэ шийдвэрийг давж заалдах эрхгүй.

ХОРИН ГУРАВ. МЭДЭГДЭЛ

23.1 Ёс зүйн зөвлөл нь ёс зүйн болзошгүй зөрчлийг шалгах шийдвэрийг гаргасан бол хариуцагчид энэ тухай бичгээр мэдэгдэх бөгөөд хуулбарыг түүний харьяалагддаг холбооны гишүүн байгууллага, клубт (хэрэв байгаа бол) илгээнэ. Гэхдээ Ёс зүйн зөвлөл энэхүү мэдэгдэл нь шалгах ажиллагаанд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй гэж үзвэл мэдэгдэл хүргүүлэх ажиллагааг түр хугацаагаар хойшлуулж болно.

Ёс зүйн дүрмийн хүрээнд Ёс зүйн зөвлөлөөс бичгээр гаргасан мэдэгдэл нь доорхи арга хэрэгслийн аль нэгээр илгээгдсэн бол хүчин төгөлдөр гэж үзнэ.

а) Хариуцагчийн бүртгэлд тэмдэглэгдсэн хаяг руу шуудангаар илгээсэн



- б) Биечлэн хүргэж өгөх замаар (гараас гарт болон зарлагаар дамжуулан үйлчлэлд хамаарах этгээдийн хаягаар)
- в) Хариуцагчийн бүртгэл, гишүүнчлэлийн хуудсанд мэдүүлэгдсэн цахим шуудан эсвэл бусад цахим харилцааны хэрэгслээр

Хариуцагч нь МУССХ-ны гишүүн байгууллага, клубт харьяалагддаг эсвэл гишүүн нь бол мэдэгдлийг тухайн байгууллага клубт дээрхи арга хэрэгслийн аль нэгнээр илгээж болно. МУССХ-ны гишүүн байгууллага, клуб нь мэдэгдлийг цааш хариуцагчид цаг алдалгүй дамжуулах, дамжуулсан тухайгаа Ёс зүйн зөвлөлд мэдээлэх үүрэгтэй. Ёс зүйн зөвлөл нь хариуцагчид хэрхэн өөрсөдтэй нь холбогдох талаар зааварчилгааг өгнө.

23.2 Мэдэгдэлд дараах зүйлсийг тусгасан байна.

- а) Үйлдсэн байж болзошгүй гэж үзэж байгаа ёс зүйн зөрчил (дүрмийн зөрчигдсөн байж болох тодорхой зүйл заалтууд)
- б) Тухайн болзошгүй зөрчлийн талаархи баримт мэдээллийн хураангуй
- в) Уг зөрчилтэй холбогдуулан оногдуулж болзошгүй шийтгэл, эрх хасах арга хэмжээний хураангуй
- г) Дүрмийн 23.3 зүйлд заасны дагуу хариуцагчид мэдэгдэлд хариу тайлбар өгөх эрхийг сануулсан байна

23.3 Хариуцагч нь мэдэгдэлд дараах байдлуудын аль нэгээр хариу өгч болно.

- а) Мэдэгдэлд дурьдсан зөрчил болон болзошгүй үр дагавар, шийтгэлийг хүлээн зөвшөөрөх
- б) Мэдэгдэлд дурьдсан зөрчлөө хүлээн зөвшөөрсөн ч, болзошгүй үр дагавар, шийтгэлийг хэсэгчлэн болон бүхэлд зөөлрүүлэн шийдвэрлэж өгөхийг хүсэх
- в) Мэдэгдэлд дурьдсан зөрчлийг үл хүлээн зөвшөөрөх

23.4 Хариуцагч нь тогтоосон хугацаанд хариу тайлбар мэдүүлгээ ирүүлээгүй тохиолдолд ёс зүйн зөрчил болон болзошгүй үр дагавар, шийтгэлийг хүлээн зөвшөөрсөнд тооцно. Шийтгэлийн талаархи мэдээллийг дүрмийн 32.8 зүйлд заасны дагуу нийтэд мэдээлнэ. Энэ шийдвэрийг давж заалдах эрхгүй.

23.5 Хариуцагч нь зөрчил болон болзошгүй үр дагавар, шийтгэлийг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд мэдэгдэлд дурьдсан шийтгэлийг оногдуулан шийдвэрлэнэ. Шийтгэлийн талаархи мэдээллийг дүрмийн 32.8 зүйлд заасны дагуу нийтэд мэдээлнэ. Энэ шийдвэрийг давж заалдах эрхгүй.

23.6 Хариуцагч нь зөрчлийг үл хүлээн зөвшөөрсөн болон болзошгүй үр дагавар, шийтгэлийг хэсэгчлэн болон бүхэлд зөөлрүүлэн шийдвэрлэж өгөхийг хүссэн тохиолдолд Ёс зүйн зөвлөлийн гишүүн дүрмийн 24 зүйлд заасны дагуу Зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэх зөвлөлд оруулан шийдвэрлүүлэх хүсэлт гаргана.



ХОРИН ДӨРӨВ. БОЛЗОШГҮЙ ЁС ЗҮЙН ЗӨРЧЛИЙН НОТЛОХ БАРИМТЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ

24.1 Ёс зүйн зөвлөлийн гишүүнээс болзошгүй ёс зүйн зөрчлийн хэргийн нотлох баримтыг Ёс зүйн зөвлөлийн даргад хүргүүлснээр зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэх үйл ажиллагаа эхэлнэ.

24.2 Нотлох баримтад дараах зүйлсийг тусгасан байна:

- а) Хариуцагч эсвэл түүний харьяалагддаг МУССХ-ны гишүүн байгууллага, клубын нэр, холбоо барих хаягийн мэдээлэл
- б) Болзошгүй зөрчлийн хураангуй
- в) Оролцогч талуудын ашиг сонирхлыг илэрхийлэх бүх баримт бичгүүд, гэрчийн мэдүүлэг болон шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн шинжээчийн дүгнэлт
- г) Оролцогч талуудын гаргасан шийтгэл ноогдуулах тухай болон шийтгэлийг хөнгөрүүлэх, хэрэгсэхгүй болгох талаархи хүсэлт

ХОРИН ТАВ. ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ БҮРЭЛДЭХҮҮНИЙГ ТОМИЛОХ

25.1 Ёс зүйн зөвлөлийн гишүүнээс болзошгүй ёс зүйн зөрчлийн нотлох баримтыг хүлээн авмагц Ёс зүйн зөвлөлийн дарга нь, зөрчлийн хэргийг Хянан шийдвэрлэх бүрэлдэхүүнд Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнээс гурван (3) гишүүнийг сонгож Зөрчлийн хэргийг Хянан шийдвэрлэх бүрэлдэхүүнийг бий болгож сонсголын товыг зарлана.

25.2 Ёс зүйн зөвлөлийн дарга нь Хянан шийдвэрлэх бүрэлдэхүүнд багтсан Ёс зүйн зөвлөлийн нэг (1) гишүүнийг хянан шийдвэрлэх бүрэлдэхүүний даргаар томилох бөгөөд тухайн гишүүн Сонсголыг удирдан явуулна. Хянан шийдвэрлэх бүрэлдэхүүний дарга нь бусад гишүүдийн адил саналын нэг эрхтэй байна.

25.3 Ёс зүйн зөвлөлийн дарга нь болзошгүй зөрчилд холбогдсон хариуцагчтай ямар нэгэн байдлаар ашиг сонирхлын зөрчилгүй (нэг клуб эсвэл нэг нутгийн харьяалалтай байх г.м), хэргийг үнэнч шударгаар шийдвэрлэж чадах гишүүнийг л хянан шийдвэрлэх бүрэлдэхүүний бүрэлдэхүүнд сонгон оруулна.

25.4 Тухайн болзошгүй зөрчлийн хэрэг дээр ажиллаж нотлох баримтыг бүрдүүлсэн Ёс зүйн зөвлөлийн гишүүнийг Зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэх бүрэлдэхүүнд оруулахгүй.

25.5 Зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэх бүрэлдэхүүн томилогдож, дарга нь сонсголын товыг зарласнаас хойш зөрчлийн хэргийг зөвхөн Зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэх бүрэлдэхүүн хэлэлцэж шийдвэрлэнэ.



ХОРИН ЗУРГАА. ЭСЭРГҮҮЦЭЛ

26.1 Зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэх сонсгол зарлагдсны дараа оролцогч бүх талуудад хянан шийдвэрлэх ажиллагаа эхэлсэн тухай мэдэгдлийг болзошгүй зөрчлийн хэргийн нотлох баримтын хамт хүргүүлж, тэднийг өөрсдийн зардлаар эрх зүйн туслалцаа авах боломжоор хангана. Мөн Зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэх бүрэлдэхүүний талаархи мэдээллийг талуудад өгнө.

26.2 Талууд зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэх бүрэлдэхүүний талаархи мэдээллийг хүлээх авснаас хойш долоо (7) хоногийн дотор бүрэлдэхүүнийг эсэргүүцэж болно.

26.3 Эсэргүүцэлд үндэслэлээ тайлбарлаж, холбогдох баримт, нотолгоог хавсаргана

26.4 Хянан шийдвэрлэх бүрэлдэхүүнтэй холбоотой эсэргүүцлийг Ёс зүйн зөвлөлийн дарга шийдвэрлэх бөгөөд тухайн эсэргүүцэлд дурьдагдсан гишүүнтэй уулзаж бичгээр тайлбар авсны дараа шийдвэрээ гаргана. Хэрэв Ёс зүйн зөвлөлийн даргыг эсэргүүцсэн бол Холбооны Удирдах зөвлөл эсэргүүцлийг шийдвэрлэнэ. Эсэргүүцлийг шийдвэрлэсэн шийдвэр эцсийнх байх бөгөөд шийдвэрийг давж заалдахгүй.

26.5 Мэдэгдэл хүлээж авснаас хойш долоо (7) хоногийн дотор ямар нэгэн эсэргүүцэл ирээгүй бол зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэх үйл ажиллагаа болон бүрэлдэхүүнийг хүлээн зөвшөөрсөнд тооцно.

ХОРИН ДОЛОО. ХАРИУЦАГЧИЙН ХАРИУ ТАЙЛБАР

27.1 Шаардлагатай тохиолдолд хариуцагч нь тусгай маягтыг ашиглан, тогтоосон хугацааны дотор хариу тайлбар өгнө. Тайлбарт доорхи зүйлсийг тусгана.

- а) Өөрийгөө өмгөөлсөн тайлбар
- б) Хариуцагчийн буруугүй гэдгээ нотлох баримтууд, гэрчийн мэдүүлэг болон шинжээчийн дүгнэлт
- в) Залруулга болон хариуцагчийн шийтгэлийг хөнгөрүүлэх хүсэлт
- г) Хариуцагч сонсгол явуулахыг хүсэж байгаа эсэх

27.2 Хариуцагч нь өөрийн буруугүйг нотлох баримт болон дүрэм журмын заалтуудыг аль болох бүрэн гүйцэд тодорхойлох ёстой. Бичгээр гаргасан мэдүүлэгт мөн адил холбогдох гэрчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт зэрэг нотлох баримтуудыг хавсаргана.

27.3 Хариуцагч тогтоосон хугацаанд хариу тайлбараа ирүүлээгүй нь Зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг хойшлуулах үндэслэл болохгүй бөгөөд зөрчлийн хэргийг урьд авагдсан баримт, нотолгооны хүрээнд шийдвэрлэнэ.



ХОРИН НАЙМ. НЭМЭЛТ МЭДҮҮЛЭГ БОЛОН НОТЛОХ БАРИМТУУД

28.1 Нотлох баримт Хянан шийдвэрлэх бүрэлдэхүүнд хүргэгдснээс хойш Хянан шийдвэрлэх бүрэлдэхүүний гаргасан шийдвэр болон талууд хоорондоо тохиролцсноос бусад тохиолдолд оролцогч талуудын аль нь ч шинэ баримт, нотолгоо, эд мөрийн баримтыг хянан шийдвэрлэх сонсголд хэлэлцүүлэхгүй.

28.2 Хянан шийдвэрлэх бүрэлдэхүүн нь сонсголын аль ч шатанд, аль нэг оролцогч тал эсвэл бүх талуудад тодорхой асуудлаар нэмэлт баримт, нотолгоо, гэрчийн мэдүүлэг бэлтгэж өгөх шаардлагыг өгч болно.

ХОРИН ЕС. СОНСГОЛ

29.1 Сонсголыг зохион байгуулах эсэхийг хянан шийдвэрлэх бүрэлдэхүүн өөрийн үзэмж болон бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэнэ.

29.2 Хянан шийдвэрлэх бүрэлдэхүүн сонсголыг цахимаар зохион байгуулах шийдвэр гаргаж болно.

29.3 Хариуцагч нь өөрийн мэдүүлгийг дэмжих гэрч, шинжээчдийг сонсголд ирүүлэх үүргийг хүлээнэ. Тэднийг сонсголд ирүүлэхтэй холбоотой бүх зардлыг хариуцагч тал хариуцна.

29.4 Сонсголын зохион байгуулалтыг хянан шийдвэрлэх бүрэлдэхүүний дарга хариуцна. Мөн талууд болон тэдний төлөөлөл, гэрчүүдээс утсаар тайлбар мэдүүлэг авах зохион байгуулалтыг хийж болно.

29.5 Дүрмийн дагуу нотлох баримтын бүрдлийг хангаж сонсголд оруулсан тал эхлээд тайлбар мэдүүлгээ өгөх бөгөөд дараа нь хариуцагч тал мэдүүлгээ өгнө.

29.6 Хянан шийдвэрлэх бүрэлдэхүүн нотлох баримтад авагдсан хоёр талын гэрч, шинжээчдийн мэдүүлгийг сонсоно. Хянан шийдвэрлэх бүрэлдэхүүн нь аль нэг талын гэрч, шинжээчийн мэдүүлгийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн хэрэгт хамааралгүй гэж үзвэл сонсголд оролцуулахгүй байж болно.

29.7 Сонсох ажиллагаа нэгэнт дууссаны дараа, хянан шийдвэрлэх бүрэлдэхүүн шаардснаас бусдаар талууд нэмэлт нотолгоо болон хүсэлт гаргах эрхгүй.

ГУЧ. ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

30.1 Талууд хянан шийдвэрлэх үйл ажиллагааны талаархи эсэргүүцлийг сонсголын үеэр цаг алдалгүй гаргаж болох бөгөөд тухайн эсэргүүцлийг хүлээн авах/ эсэх шийдвэрийг Хянан шийдвэрлэх бүрэлдэхүүний дарга гаргана.

30.2 Талууд өөрсдөө зардлыг нь хариуцан сонгосон төлөөлөгчөөр төлөөлүүлж эсвэл тэдний тусламжийг авч болно. Талууд нь төлөөний хүнийхээ талаархи болон холбоо барих мэдээллийг сонсгол болохоос өмнө хянан шийдвэрлэх бүрэлдэхүүнд мэдэгдэнэ.

30.3 Хянан шийдвэрлэх бүрэлдэхүүн нь талуудын үндэслэл бүхий хүсэлтийн дагуу, шаардлагатай гэж



үзвэл хянан шийдвэрлэх ажиллагааг түргэвчилсэн горимоор явуулж болно. Энэ тохиолдолд хянан шийдвэрлэх бүрэлдэхүүн түргэвчилсэн горимоор хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг тогтооно.

ГУЧИН НЭГ. БАРИМТ НОТОЛГООГ ШИНЖЛЭН СУДЛАХ

31.1 Ёс зүйн зөвлөл нь ёс зүйн дүрмийн зөрчил гарсан эсэхийг нотлох баримтыг үндэслэн тогтоох үүрэгтэй. Нотлох баримт нь тэнцвэртэй байдлыг хангасан байна.

31.2 Баримт нотолгоо нь баталгаатай эх сурвалжаас, зөв арга хэрэгслээр авагдсан байх ёстой. Хянан шийдвэрлэх бүрэлдэхүүн нь аливаа баримтыг хүлээн зөвшөөрөх, холбоо хамаарал, бодит байдал болон нотлох баримтын хөдлөшгүй байдлыг өөрсдийн үзэмжээр шийдвэрлэнэ.

31.3 Зөрчилд тохирсон хариуцлагыг зайлшгүй тооцох зарчим баримтлана. Иймээс зөрчлийг санаатай, санамсаргүй, хайхрамжгүй байдлаас болж үйдлснээс үл хамааран тохирох шийтгэлийг заавал онооно.

31.4 Доорхи тохиолдолд хянан шийдвэрлэх бүрэлдэхүүн нь хариуцагчийн эсрэг сөрөг дүгнэлт гаргаж болно. Үүнд :

- (а) Мэдээлэл, баримт бичиг, тусламж хүссэн аливаа шаардлагыг биелүүлээгүй
- (б) Сонголд өөрөө эсвэл бие төлөөлөгчөө ирүүлээгүй
- (в) Сонголын үеэр ямар ч асуултад хариулаагүй

ГУЧИН ХОЁР. ШИЙДВЭР ГАРГАХ ҮЙЛ ЯВЦ

32.1 Талууд мэдүүлэг тайлбараа өгч дууссаны дараа хянан шийдвэрлэх бүрэлдэхүүн зөрчил гарсан эсэхийг тогтооно. Зөрчил гарсан гэж үзвэл хянан шийдвэрлэх бүрэлдэхүүн нь дүрмийн 33 зүйлийн дагуу тохирох шийтгэлийг өөрийн эрх мэдэл, үзэмжээр оноож шийдвэрлэнэ.

32.2 Хянан шийдвэрлэх бүрэлдэхүүн нь баримт нотолгоог хянан хэлэлцэх бүрэн эрхтэй бөгөөд талуудын гаргасан шийтгэл хөнгөрүүлэх хүсэлтийг заавал хангах үүрэггүй.

32.3 Хянан шийдвэрлэх бүрэлдэхүүн нь шийдвэрээ гаргамагц бичгээр талуудаад хүргүүлнэ. Бичгээр гаргах шийдвэрт:

- а) Зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэсэн гишүүдийн нэр
- б) Талуудын нэр
- в) Холбогдох баримтуудын хураангуй
- г) Хянан шийдвэрлэх бүрэлдэхүүний шийдвэр
- д) Шийдвэр гаргахад үндэслэсэн ёс зүйн дүрмийн зүйл заалт, ишлэл
- е) Ёс зүйн дүрмийн зөрчил гарсан тухай шийдвэр гаргасан шалтгаан, оноосон шийтгэлийн эхлэх хугацаа (хэрэв байгаа бол)
- ж) Шаардлагатай тохиолдолд зардлын талаархи шийдвэр



з) Удирдах зөвлөлд давж заалдах гомдол гаргах боломж болон боломжит хугацаа

32.4 Хянан шийдвэрлэх бүрэлдэхүүн шийдвэрээ Ёс зүйн дүрэм болон МУССХ-ны дүрэм, журмуудыг баримтлан гаргана.

32.5 Хянан шийдвэрлэх бүрэлдэхүүн нь шийдвэрээ бүгд санал нэгдэж эсвэл олонхийн саналаар гаргана. Хянан шийдвэрлэх бүрэлдэхүүн нь заавал бүрэн бүрэлдэхүүнээрээ шийдвэр гаргана.

32.6 Хянан шийдвэрлэх бүрэлдэхүүн нь бичгээр гаргасан шийдвэрт байгаа аливаа утга найруулга, үг үсгийн, хэвлэлтийн болон бусад ижил төстэй шинж чанартай алдаануудыг дараа нь засаж залруулж болно.

32.7 Шийдвэрийг талуудад танилцуулсан болон захидал, цахим шуудангаар илгээсэн даруй хүчин төгөлдөр үйлчилж эхэлнэ.

32.8 Шийдвэрийн хуулбарыг үйлчлэлд хамаарах этгээдийн харьяалагдаг МУССХ-ны гишүүн байгууллага, клубт илгээнэ (хэрэв байгаа бол). Шийдвэрийг хүлээн авсан даруй МУССХ нь олон нийтэд өөрийн харилцаа холбооны сувгуудыг ашиглан мэдээлнэ. Хэрэв үйлчлэлд хамаарах этгээдийг ёс зүйн зөрчил гаргаагүй гэсэн шийдвэр гарсан бол зөвхөн түүнийг зөвшөөрсөн тохиолдолд олон нийтэд мэдээлж болно. Хянан шийдвэрлэх бүрэлдэхүүн нь олон нийтэд мэдээлэхэд зориулан шийдвэрийн зарим хэсгийг хураангуйлж болно.

ГУЧИН ГУРАВ. ШИЙТГЭЛ

33.1 Ёс зүйн зөрчил гаргасан этгээдэд дараах шийтгэлүүдийн аль нэгийг эсвэл хэд хэдэн шийтгэлийг ноогдуулж болно.

а) дахин зөрчил гаргахгүй байх талаар анхааруулах

б) сануулга өгөх

в) зөрчлийн хор хохирол, хэмжээнд тохирсон хэмжээгээр торгох

г) хохирлыг нөхөн төлөх

д) МУССХ-ны арга хэмжээнд туслуулах

е) МУССХ-ны нэрийн өмнөөс тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг түтгэлзүүлэх

ж) эрх хасах, түтгэлзүүлэх шийтгэлийн үргэлжлэх хугацааг тухайн зөрчлийн шинж чанартай уялдуулан дараах нөхцлүүдийг тооцоолсны үндсэн дээр тогтооно. Үүнд:

- Зөрчлийн шинж чанар

- Үйлчлэлд хамаарах этгээдийн гаргасан зөрчлийн хэм хэмжээ

- Усан спортод учруулсан хор уршиг

- Ирээдүйд гарах зөрчлөөс урьдчилан сэргийлэх

- Хөнгөрүүлэх болон хүндрүүлэх нөхцөл



з) Арга хэмжээний үр дүнг хүчингүй болгох, албан тушаалаас нь чөлөөлөх, зохион байгуулах эрхийг хураах, сургалтанд хамрагдахыг шаардах, шагнал урамшууллыг буцаан хураах гэх мэт бүх төрлийн зөрчилтэй холбогдох шийтгэлүүд

33.2 Зөрчлийн ноцтой байдал болон холбогдох бусад нөхцлөөс шалгаалан шийтгэлийг хөнгөрүүлж эсвэл хүндрүүлэн оногдуулж болно.

33.3 Хүндрүүлэх хүчин зүйлүүдэд:

- а) Хариуцагч этгээдийн нас, туршлага, хүлээсэн үүрэг, албан тушаал (жишээ нь: багийн дасгалжуулагч, холбооны албан тушаалтан г.м)
- б) Хариуцагч өмнө нь ёс зүйн зөрчил гаргаж шийтгэл авч байсан бол
- в) Хариуцагч нь ёс зүйн дүрмийн нэгээс олон заалтыг зөрчсөн эсвэл нэг заалтыг удаа дараа зөрчсөн нь тогтоогдсон бол
- г) Хариуцагч нь ёс зүйн зөрчлийн үйлдлээрээ багагүй хэмжээний ашиг хонжоо олсон эсвэл олохоор төлөвлөж байсан нь тогтоогдсон бол
- д) Хариуцагчийн зөрчил нь арга хэмжээний үр дүнд нөлөөлсөн эсвэл нөлөөлж болзошгүй байсан нь тогтоогдсон бол
- е) Зөрчил нь өөр нэгэн үйлчлэлд хамаарах этгээдийн томоохон зөрчлийн нэг хэсэг байсан нь тогтоогдсон бол
- ж) Ёс зүйн зөрчлийн шалгалтын явцад болон хянан шийдвэрлэх ажиллагаа, сонсголын үеэр хариуцагч нь асуултанд худлаа, дутуу хариулах, хариулахгүй байх, шалтгаангүй хэрүүл маргаан үүсгэх зэргээр саад учруулахыг оролдсон бол
- з) Хариуцагч нь гаргасан зөрчилдөө гэмшихгүй байх (жишээлбэл: Ёс зүйн сургалтанд хамрагдахаас татгалзах).

33.4 Хөнгөрүүлэх хүчин зүйлүүдэд:

- а) Хариуцагчийн залуу нас, туршлагагүй байдал болон түүнийг нь ахмад настай, илүү туршлагатай нэгэн өөртөө давуу байдал болгон ашигласан нь тогтоогдсон бол
- б) Хариуцагчийн өмнөх сахилга батын сайн тодорхойлолт
- в) Хариуцагч нь ёс зүйн зөрчлийн үйлдлээрээ ашиг хонжоо олоогүй, олохоор төлөвлөж байгаагүй нь тогтоогдсон бол
- г) Хариуцагчийн зөрчил арга хэмжээний үр дүнд нөлөөлөөгүй эсвэл нөлөөлөх боломжгүй байсан нь тогтоогдсон бол
- д) Хариуцагч гаргасан зөрчлөө цаг тухайд нь хүлээн зөвшөөрсөн
- е) Ёс зүйн зөрчлийн шалгалтын явцад болон хянан шийдвэрлэх ажиллагаа, сонсголын үеэр хариуцагч нь шаардсан мэдээллийг бүрэн гүйцэд өгөх, асуултанд үнэн зөв хариулах, сайн



дураараар хамтран ажилласан бол

ж) Хариуцагч нь бусад этгээдийн үйлдсэн Ёс зүйн дүрэм болон бусад хууль тогтоомж, журмын зөрчлийг илрүүлэхэд хамтран ажилласан бол

з) Хариуцагч нь гаргасан зөрчлөө хүлээн зөвшөөрч, гэмшиж байгаа бол (жишээлбэл: Ёс зүйн сургалтанд хамрагдахыг зөвшөөрөх).

33.5 Хариуцагч нь нэгээс олон тооны зөрчил гаргасан бол шийтгэлийг хамгийн ноцтой зөрчилд нь тулгуурлан оноох бөгөөд бусад зөрчлийн онцлогоос хамааран шийтгэлийн хэмжээг нэмэгдүүлж болно

33.6 Хянан шийдвэрлэх бүрэлдэхүүнээс хариуцагчид дүрмийн 33 зүйлд заасан эрх хасах шийтгэл оноосон бол шийтгэлийн хугацааг тухайн шийдвэр гарсан өдрөөс эхлэн тооцно. Хэрэв үйлчлэлд хамаарах этгээдийн эрх шийдвэр гарахаас өмнө түтгэлзсэн байсан бол түтгэлзсэн хугацааг шийтгэлийн хугацаанаас хасаж тооцно.

33.7 Хянан шийдвэрлэх бүрэлдэхүүнээс тодорхой нөхцөл бүрэлдэх хүртэл оноосон шийтгэлийн хэрэгжилтийг бүхэлд нь болон хэсэгчлэн түтгэлзүүлж болно.

33.8 Эрхээ хасуулсан болон эрх нь түр түтгэлзсэн хугацаанд үйлчлэлд хамаарах этгээд нь:

- Аливаа арга хэмжээнд оролцохыг

- МУССХ-ны болон дэлхийн усан спортын холбоо, тэдний нэрийн өмнөөс зохион байгуулж буй усны холбогдолтой бүхий л үйл ажиллагаанд оролцохыг

- МУССХ-нд ямар нэгэн албан тушаал хаших, эсвэл нэр дэвшин өрсөлдөхийг тус тус хориглоно.

Тайлбар: Эрх хассан шийтгэлийг зөрчсөн аливаа үйлдлийг ёс зүйн зөрчил гэж үзэх бөгөөд зөрчлийг дүрмийн Дөрөв дүгээр бүлэгт заасны дагуу шийдвэрлэнэ.

33.9 Хариуцагч нь дүрмийн 33.8 зүйлийг зөрчсөн нь тогтоогдвол түүний эрх хасах шийтгэл дуусахад ямар хугацаа үлдсэн байснаас үл хамааран эрх хасах шийтгэлийн хугацааг тухайн өдрөөс дахин эхлүүлж, тухайн арга хэмжээнээс нэн даруй хасаж, үр дүнг нь хүчингүй болгоно.

33.10 Хариуцагчийн эрх хасах шийтгэлийн хугацаанд гаргасан аливаа зөрчлийг тусад нь авч үзэж шалган, хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах бөгөөд энэ хугацаанд түүний эрх хасах шийтгэл хүчин төгөлдөр үйлчлэнэ.

ГУЧИН ДӨРӨВ. ЗАРДАЛ

34.1 Хянан шийдвэрлэх бүрэлдэхүүнээс өөрөөр шийдээгүй бол хянан шийдвэрлэх ажиллагаа ямар нэг төлбөргүй явагдана.

34.2 Талууд зөрчлийн болзошгүй хэргийг шалгах, хянан шийдвэрлэх сонсголд оролцуулахаар томилсон өөрсдийн хууль ёсны төлөөлөгч, эрх зүйн туслалцаа үзүүлэгч, шинжээчийн зардлыг өөрсдөө хариуцна.



34.3 Хариуцагчийн эрх хасах, түтгэлзүүлэх шийтгэлийн хугацаа дууссан хэдий ч хянан шийдвэрлэх бүрэлдэхүүнээс МУССХ-нд төлөхийг даалгасан аливаа торгууль, шийтгэврийг бүрэн төлж барагдуулаагүй бол аливаа арга хэмжээнд оролцох эрх, нэр дэвших, албан тушаал хаших эрх нь сэргээгүйд тооцогдоно. Гэхдээ төлбөрийг хэсэгчлэн төлөхөөр МУССХ-той тохиролцож гэрээ байгуулсан, гэрээний үүргээ хугацаанд нь биелүүлж байгаа бол эрх хасах, түтгэлзүүлэх шийтгэлийн хугацаа дууссанаар үйлчлэлд хамаарах этгээдийн эрхийг сэргээсэнд тооцно.

ГУЧИН ТАВ. УДИРДАХ ЗӨВЛӨЛД ДАВЖ ЗААЛДАХ

35.1 Хянан шийдвэрлэх бүрэлдэхүүний ёс зүйн зөрчил гарсан талаархи эцсийн шийдвэр гарсны дараа аль нэг тал нь санал нийлэхгүй байвал МУССХ-ны Удирдах зөвлөлд давж заалдах хүсэлтээ өгч болно.

35.2 Давж заалдах хүсэлтийг хянан шийдвэрлэх бүрэлдэхүүний шийдвэрийг бичгээр болон цахим шуудангаар илгээсэн өдрөөс хойш хуанлийн 14 хоногийн дотор Удирдах зөвлөлд хүргүүлсэн байна. Мөн давж заалдах хүсэлтийн хуулбарыг нөгөө талд давхар хүргүүлнэ. Давж заалдах хүсэлтийг Удирдах зөвлөл өөрийн эрх мэдэл, дүрэм журмын хүрээнд шийдвэрлэнэ.

35.3 Удирдах зөвлөлд давж заалдах нь шийтгэлийг түтгэлзүүлэх үндэслэл болохгүй. Удирдах зөвлөлөөс давж заалдахтай холбоотой ямар нэгэн шийдвэр гарах хүртэл хянан шийдвэрлэх бүрэлдэхүүний тогтоосон шийтгэл хүчин төгөлдөр үйлчилнэ.

35.4 Ёс зүйн дүрмийн хүрээнд шийдвэрлэх боломжгүй аливаа асуудлыг Монгол улсын хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлүүлнэ.

ГУЧИН ЗУРГАА. ШИЙДВЭРИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ

36.1 Ёс зүйн дүрмийн хүрээнд Хянан шийдвэрлэх бүрэлдэхүүн эсвэл Удирдах зөвлөлөөс гаргасан аливаа шийдвэрийг МУССХ-ны сонгогдсон болон томилогдсон бүх албан хаагчид, тамирчид, туслан дэмжигчид, гишүүд, гишүүн байгууллага, клубууд, хамтрагчид хүлээн зөвшөөрч, дагаж мөрдөнө.

36.2 Дэлхийн усан спортын холбоо (World Aquatics)-ны Ёс зүйн дүрмийн (Integrity Code) 36.2 зүйлд заасны дагуу МУССХ-ны ёс зүйн зөрчлийг Хянан шийдвэрлэх зөвлөлөөс гаргасан аливаа шийдвэрийг Дэлхийн усан спортын холбоо болон түүний гишүүн холбоод хүндэтгэн хүлээн авч, биелэлтийг хангахад өөрсдийн боломжоор туслана.

36.3 МУССХ нь бусад спорт холбоодын эрх бүхий байгууллагын ёс зүйн дүрмийнхээ хүрээнд гаргасан аливаа эцсийн шийдвэрийг хүндэтгэн хүлээн зөвшөөрч, хэрэгжилтэнд нь өөрсдийн эрх мэдлийн хүрээнд туслана. Ингэж хүлээн зөвшөөрөх нь үйлчлэлд хамаарах этгээдэд МУССХ-ны зүгээс ёс зүйн дүрмийнхээ хүрээнд нэмэлт шийтгэл оногдуулахад саад болохгүй. Бусад спорт холбоодын ёс зүйн асуудлаар гаргасан шийдвэр нь МУССХ-ны дүрэм, үнэт зүйл, зарчмуудад харшилж байна гэж үзвэл



хүлээн зөвшөөрөхгүй байж болно.

ГУЧИН ДОЛОО. ДҮГНЭЛТ ГАРГАХ

37.1 МУССХ-ны албан тушаалд нэр дэвшин өрсөлдөж эсвэл томилогдож байгаа аливаа этгээдийг тухайн албан тушаалд нэр дэвшиж эсвэл томилогдож болох эсэх талаархи дүгнэлтийг Ёс зүйн зөвлөл гаргана.

37.2 Ёс зүйн зөвлөл нь дээрхи дүгнэлтээ гаргахын тулд тухайн хүн эсвэл түүний харьяалагддаг гишүүн байгууллага клубээс нь нэмэлт баримт, мэдээлэл гаргаж өгөхийг хүсэж болно.

37.3 Ёс зүйн зөвлөл нь нэр дэвшин өрсөлдөх, томилогдох боломжгүй гэдгийг урьдчилсан байдлаар дүгнэсэн бол энэхүү шийдвэрээ үндэслэл бүхий тайлбарын хамт тухайн этгээдэд нууцаар хүргүүлнэ. Ёс зүйн зөвлөл нь тухайн этгээдэд хариу тайлбараа өгөх эцсийн хугацааг мөн тогтоож өгнө. Тус хариу тайлбарыг авч судалсны үндсэн дээр Ёс зүйн зөвлөл нь эцсийн шийдвэрээ гаргана.

37.4 Шийдвэрийг Ёс зүйн зөвлөлийн энгийн олонхийн саналаар гаргана.

37.5 Ёс зүйн зөвлөл нь гаргасан дүгнэлтээ тухайн этгээд болон МУССХ-ны Ерөнхийлөгч, Ерөнхий нарийн бичгийн дарга, Их хурал, түүний сонгуулийн комисс зэрэг холбогдох этгээдүүдэд хүргүүлнэ.

37.6 Нэр дэвшин өрсөлдөж эсвэл томилогдох боломжгүй гэсэн дүгнэлт авсан этгээд Удирдах зөвлөлд давж заалдаж болно. Ёс зүйн зөвлөлийн эцсийн шийдвэрийг хүлээж авснаас хойш арав (10) хоногийн дотор давж заалдаж болох бөгөөд Удирдах зөвлөл энэ асуудлыг түргэвчилсэн журмаар шийдвэрлэнэ.